3. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний бүртгэлийн газрын дарга Д.Энхцэцэг, Мэдээлэл технологийн газрын дарга С.Чинбат, аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн газар, хэлтсийн дарга, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга Д.Дэлгэрсайханд тус тус үүрэг болгосугай.

4. Журам батлагдсантай холбогдуулан Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны А/187 тоот "Журам батлах тухай" тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү журмыг холбогдох хуулийн дагуу Монгол Улсын хуулийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий  
газрын даргын 2017 оны 292 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт



## СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ ҮЙЛДЭХ, ТАНИЛЦУУЛАХ, ДАВХАРДЛЫГ ШАЛГАХ, СОНГОГЧ ШИЛЖИХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах, нягтлан шалгаж, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй иргэнийг бүртгэх, сонгуулийн эрх бүхий иргэний иргэний улсын бүртгэлийн өөрчлөлтийг тусгах, сонгогч шилжих, сонгогчдын нэрийн жагсаалтыг хүргүүлэх, санал авах өдөр сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбараас иргэний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/- өөр, гарын хурууны хээ шалгах төхөөрөмж ажиллах боломжгүй болсон, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн иргэний үнэмлэхийн регистрийн дугаараар тулган шалгаж бүртгэлийн хуудас олгох болон сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхтэй холбогдсон бусад үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, нягтлан шалгах, өөрчлөлт оруулахтай холбоотой үйл ажиллагаанд Сонгуулийн тухай хууль болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### Хоёр. Сонгуулийн хэсгийн дугаарыг тогтоох, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгуулийн хэсэгт бүртгэх, нягтлан шалгах,

2.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугчдын байнга оршин суугаа газрын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн гаргасан сонгуулийн эрх бүхий иргэний тоог Сонгуулийн тухай хуулийн 23.1 дэх хэсэгт заасан хугацаанд аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээр дамжуулан сум, дүүргийн хурлын Тэргүүлэгчид хүргүүлнэ.

2.2. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь сум, дүүргийн хурлын Тэргүүлэгчдээс Сонгуулийн тухай хуулийн 23.5 дахь хэсэгт заасан хугацаанд хэсгийн нутаг дэвсгэр, төвийг зарласан тогтоолыг хүлээн авна.

2.3. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын /ахлах/ бүртгэгч нь сум, дүүргийн хурлын Тэргүүлэгчдийн сонгуулийн хэсэг байгуулсан тогтоолыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор санал авах байр, түүнд хамаарах хаягийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгана.

2.4. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс нь энэ журмын 2.3-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэж дуусмагц, сум, дүүргийн хурлын Тэргүүлэгчдийн сонгуулийн хэсэг байгуулсан тогтоолын эх хувийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгийн хамт хүргүүлнэ.

2.5. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Иргэний улсын бүртгэл хариуцсан нэгж нь иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд энэ журмын 2.3-д заасны дагуу тусгасан мэдээллийг сум, дүүргийн хурлын Тэргүүлэгчдийн сонгуулийн хэсэг байгуулсан тогтоолын мэдээлэлтэй тулган шалгана.

2.6. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Мэдээллийн технологи хариуцсан нэгж нь иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгасан энэ журмын 2.5-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэж дуусмагц, иргэний улсын

бүртгэлийн мэдээллийн санд сонгуулийн хэсгийг улсын хэмжээнд нэгээс эхлэн давхардахгүй байхаар дугаарлана.

2.7. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Иргэний улсын бүртгэл хариуцсан нэгж нь сонгуулийн хэсгийн дугаар тогтоосон тухай улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалыг Сонгуулийн ерөнхий хороонд 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.8. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь энэ журмын 2.6 дахь хэсэгт заасан мэдээллийг үндэслэн сонгуулийн хэсэгт хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэнд хэсэг оноох ажлыг гүйцэтгэнэ.

2.9. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эрх бүхий улсын /ахлах/ бүртгэгч энэ журмын 2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэж дуусмагц, хэсэг оноогдсон сонгогчдын мэдээллийг нягтлан шалгана:

2.9.1. сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэн сонгуулийн хэсэгт бүрэн бүртгэгдсэн эсэх;

2.9.2. сонгуулийн эрх бүхий иргэний мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэгдсэн эсэх;

2.9.3. сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний улсын бүртгэлийн өөрчлөлт тусгагдсан эсэх;

2.9.4. сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий иргэнийг оруулсан эсэх;

2.9.5. сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэлтэй нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан иргэн сонгуулийн хэсэгт бүртгэгдсэн байх эсэх.

2.10. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эрх бүхий улсын /ахлах/ бүртгэгч энэ журмын 2.9-д заасан мэдээллийг бүрэн нягтлан шалгаж дуусмагц, Сонгуулийн тухай хуулийн 61.6 дахь хэсэгт заасан хугацаанаас өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад дараах өөрчлөлтийг оруулна:

2.10.1. сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний жагсаалтад бүртгэгдээгүй иргэнийг нэмж бүртгэх;

2.10.2. энэ журмын 2.9.2, 2.9.3-т заасан нөхцөл үүссэн бол нотлох баримтыг үндэслэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд мэдээллийг тусгах;

2.10.3. энэ журмын 2.9.4-т заасан нөхцөл үүссэн бол иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн мэдээллийг үндэслэн нэмэх;

2.10.4. энэ журмын 2.9.5-т заасан сонгуулийн эрх бүхий иргэний холбогдох бүртгэлийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулж, сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах.

**Гурав. Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудаст байрлуулах, танилцуулах, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, түүнд өөрчлөлт оруулах**

3.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгогчдын нэрийн жагсаалтыг Сонгуулийн тухай хуулийн 61.6 дахь хэсэгт заасан хугацаанд өөрийн [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хуудаст байрлуулна.

3.2. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь цахим хуудаст байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад Сонгуулийн тухай хуулийн 61.12 дахь хэсэгт заасан өөрчлөлтийг тусгана.

3.3. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хүргүүлсэн програмд сонгуулийн тухай хуулийн 61.8 дахь хэсэгт заасан төрийн

байгууллага нь сонгуулийн насны иргэдийн мэдээллийг тусгаж, санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө цахим болон цаасан хэлбэрээр ирүүлнэ.

3.4. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Сонгуулийн тухай хуулийн 61.9 дэх хэсэгт заасан үндэслэлийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалт дахь тухайн сонгогчийн нэрийн арын "Тайлбар" гэсэн хэсэгт "Түр хасав" гэсэн нэмэлт тэмдэглэгээг хийнэ.

3.5. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэлтэй сонгогчдын нэрийн жагсаалтаас Сонгуулийн тухай хуулийн 61.11 дахь хэсэгт заасан сонгогчдын нэрийг хасна.

3.6. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэлтэй сонгогчдын нэрийн жагсаалтаас Сонгуулийн тухай хуулийн 62.7 дахь хэсэгт заасан Гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчийн нэрийг хасна.

3.7. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нягтлан шалгаж, зөрчилтэй сонгогчийн нэрийг хасч сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэнэ.

#### **Дөрөв. Сонгогчдын нэрийн жагсаалтыг аймаг, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст хүргүүлэх**

4.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр өөрчлөлт орсон сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нягтлан шалгаж, сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээллийн санг үүсгэнэ.

4.2. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэж, Сонгуулийн тухай хуулийн 61.12-т заасан хугацаанд аймаг, дүүргийн сонгуулийн хороонд 2 хувийг нь хүргүүлнэ.

4.3. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаад улсад санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаад, салбар комисст санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр буцаан хүргүүлнэ.

4.4. Сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээлцэж буй этгээдүүд нь хүлээлцсэн тухай актыг 2 хувь үйлдэж, гарын үсэг зурна.

4.5. Салбар комисс энэ журмын 4.3-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан тухайгаа улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хаягаар ирүүлнэ.

#### **Тав. Сонгуулийн хэсгийн санал авах байранд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах**

5.1. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын /ахлах/ бүртгэгч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас дараах лавлагааг гаргаж, сум хорооны улсын бүртгэгчид 3 хоногийн дотор хүргүүлнэ:

5.1.1. Сонгуулийн тухай хуулийн 64.1 дэх хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтанд сонгогчийг нэмэх лавлагаа;

5.1.2. Сонгуулийн тухай хуулийн 64.4 дэх хэсэгт заасны дагуу "Түр хасав" тэмдэглэгээг сэргээсэн тухай лавлагаа;

5.1.3. Сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн өөрчлөлтийн тухай иргэний улсын бүртгэлийн лавлагаа;

5.1.4. Сонгуулийн тухай хуулийн 61.12.4 дэх хэсэгт заасан нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан бүртгэлийн лавлагаа;

5.1.5. Сонгуулийн тухай хуулийн 65.2 дахь хэсэгт заасан сонгуулийн хэсгээс сонгогч шилжин явсан, сонгогч шилжин ирсэн лавлагаа;

5.1.6. Сонгуулийн тухай хуулийн 62.7 дахь хэсэгт заасан гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчийг хасах лавлагаа

5.2. Сум, хорооны улсын бүртгэгч энэ журмын 5.1 дэх хэсэгт заасан лавлагааг санал авах байранд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд нэн даруй хүлээлгэн өгнө.

5.3. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 5.1-д заасан лавлагааны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарт санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө өөрчлөлт оруулна.

5.4. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарт оруулсан өөрчлөлтийг лавлагаа тус бүрээр тулган шалгаж, сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө хэвлэнэ.

5.5. Сонгогчдын нэрийн жагсаалт, сонгогчдын нэрийн жагсаалтын өөрчлөлтийн тайлангийн 1 хувийг аймаг, дүүргийн сонгуулийн хороонд актаар хүлээлгэн өгнө.

5.6. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан энэ журамд заасан лавлагаа болон сонгогчдын нэрийн жагсаалтын өөрчлөлтийн тайлангийн 1 хувийг санал авах байранд өгөх бөгөөд санал авах байр энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

5.7. Энэхүү журамд заасан лавлагааг зөвхөн улсын бүртгэлийн байгууллагын салбар, нэгжээс олгох бөгөөд газар, хэлтсийн дарга, сум, хорооны улсын бүртгэгчийн гарын үсэг, тэмдэг, итгэмжлэгдсэн ажилтны гарын үсгээр тус тус баталгаажсан байна.

5.8. Лавлагаа нь бар код, давтагдашгүй дугаар бүхий үнэт цаасан дээр хэвлэгдсэн байна.

5.9. Улсын бүртгэлийн байгууллагын холбогдох салбар, нэгжийн улсын /ахлах/ бүртгэгч, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нь сонгогчдын нэрийн жагсаалтад оруулах өөрчлөлтийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргасан лавлагааг үндэслэн оруулах, нягтлан шалгах, оруулсан өөрчлөлтийн үнэн зөвийг тус тус хариуцна.

### **Зургаа. Сонгогч шилжих**

6.1. Сонгогч шилжихдээ Сонгуулийн тухай хуулийн 65.2 дахь хэсэгт заасан санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа санал авах байранд батлагдсан маягтын дагуу хүсэлт гаргана.

6.2. Санал авах байр шилжин явах сонгогчийн иргэний үнэмлэх болон шалтгааныг үндэслэн "Сонгогч шилжих хуудас"-т тухайн сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа хаягийг бичиж, санал авах байрын ахлах зохион байгуулагч гарын үсэг зурж, сонгуулийн хэсгийн тэмдэг дарж баталгаажуулна.

6.3. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан санал авах байрын ахлах зохион байгуулагчийн баталгаажуулсан "Сонгогч шилжих хуудас"-ыг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалт дахь "Тайлбар хэсэгт" сонгогч шилжин явсан тухай тэмдэглэн, "Сонгогч шилжин явсан тухай" хэсгийг авч, хуудсыг иргэнд олгоно.

6.4. Санал авах байр шилжин ирсэн сонгогчийн иргэний үнэмлэхийг үндэслэн "Сонгогч шилжих хуудас"-т шилжин ирсэн тухай тэмдэглэж, хуудсыг улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд шилжүүлнэ.

6.5. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 6.4-т заасан "Сонгогч шилжих хуудас"-ыг үндэслэн сонгогчийн нэрийн жагсаалтад сонгогчийг нэмж бүртгэж, "Тайлбар" хэсэгт сонгогч шилжин ирсэн тухай тэмдэглэнэ.

6.6. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нь сонгогч шилжин явсан, сонгогч шилжин ирсэн тухай мэдээллийг жагсаалтаар сум, хорооны улсын бүртгэгчид 2 хоногийн дотор хүргүүлнэ. Сум, хорооны улсын бүртгэгч аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлнэ.

6.7. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эрх бүхий улсын бүртгэгч энэ журмын 6.6-д заасан мэдээллийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгаж, энэ журмын 5.1.5-д заасан лавлагааг итгэмжлэгдсэн ажилтанд хүргүүлнэ.

### **Долоо.Санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг тулган шалгаж, бүртгэлийн хуудас олгох**

7.1.Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нь сонгуулийн санал авах өдөр сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэлийг бүрэн хариуцан ажиллах ба саналаа өгөхөөр ирсэн сонгогчийн мэдээллийг тухайн сонгуулийн хэсгийн сонгогчдын цахим бүртгэлийн сангаас дараах байдлаар шалгана:

7.1.1. сонгогч биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг уншуулан таниулж, сонгогчийн цахим бүртгэл дэх зураг, мэдээллийг тулгах;

7.1.2. хэрвээ тухайн сонгогчийн хурууны хээ уншигдахгүй бол сонгогчийн иргэний үнэмлэх дэх регистрийн дугаар, оршин суух хаяг, гэрэл зургийг сонгогчийн цахим бүртгэлийн мэдээлэлтэй тулгаж, тэмдэглэл үйлдэх.

7.2. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан цахим хэлбэр бүхий сонгогчдын нэрийн жагсаалтаас "Бүртгэлийн хуудас"-ыг хэвлэж, сонгогчид олгоно.

7.3. Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгсөн сонгогчийн регистрийн дугаарыг сонгогчийн цахим бүртгэлийн мэдээллийн санд уншуулан бүртгэлийн хуудсыг хэвлэж, 1 хувийг санал авах байрын ахлах зохион байгуулагчид өгнө.

7.4.Сонгогчдын нэрийн жагсаалтыг хөтлөхөөр үүрэг хүлээсэн санал авах байрын зохион байгуулагч энэ журмын 7.2-т заасны дагуу олгосон сонгогчийн "Бүртгэлийн хуудас"-ын 1 хувийг хураан авч, сонгогчдын нэрийн жагсаалтад сонгогчоор гарын үсэг зуруулна.

7.5. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 7.1-д заасны дагуу сонгогчийн мэдээллийг шалгахад тухайн сонгогч уг санд бүртгэгдээгүй бол "Бүртгэлийн хуудас"-ыг олгохгүй.

7.6. Сонгогчийн иргэний үнэмлэхийн хаягийн бичвэр нь сонгогчдын нэрийн жагсаалтын хаягийн бичвэрээс бичилт өөр боловч нэг утгыг илэрхийлж байвал Бүртгэлийн хуудас-ыг олгоно.

7.7. Санал авах өдөр Сонгуулийн тухай хуулийн 64.4-т заасан үндэслэлээр сонгогчийн нэрийн жагсаалтад "Түр хасав" нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн сонгогчийн бүртгэлийг дараах журмын дагуу сэргээнэ:

7.7.1.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгуулийн хэсгийн ахлах зохион байгуулагч, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нарт сонгогчийн цахим бүртгэлийн сангийн "Түр хасав" тэмдэглэгээг сэргээх кодыг санал авахаас 3-аас доошгүй хоногийн өмнө хүлээлгэн өгсөн байна.

7.7.2. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан энэхүү журмын 7.7-д зааснаар сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдлийн мэдээллийг шалгаж, сонгуулийн

хэсгийн ахлах зохион байгуулагчид мэдэгдэж, бүртгэлийг сэргээх талаар протокол үйлдэнэ.

7.7.3. Энэ журмын 7.7.1-д заасан сэргээх кодыг улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан, сонгуулийн хэсгийн ахлах зохион байгуулагч нар сонгогчийн цахим бүртгэлийн санд оруулан иргэнд энэхүү журмын 7.2-т заасан "Бүртгэлийн хуудас"-ыг олгоно.

7.8. Энэхүү журмын 7.7-д заасны дагуу "Түр хасав" тэмдэглэгээг сэргээсэн сонгогч сонгогчийн нэрийн жагсаалтанд гарын үсэг зурж, баталгаажуулна.

7.9. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан санал авах өдөр сонгогчийн бүртгэлийн нээлтийн, зөврийн хайрцагийн, явцын, "Түр хасав"-аас сэргээсэн болон хаалтын тайланг тогтоосон хугацаанд хэвлэж, сум, дүүргийн улсын бүртгэгчид мэдээлнэ.

7.10. Энэ журамд заасан сонгогчдын бүртгэлийн мэдээг сум, дүүргийн улсын бүртгэгч аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст, аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн батлагдсан маягтын дагуу тогтоосон хугацаанд ирүүлнэ.

#### **Найм. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан**

8.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь итгэмжлэгдсэн ажилтны ажиллах орон тооны хязгаар, ажил үүргийн хуваарийг батална.

8.2. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтныг тагнуулын байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын аймаг, нийслэл дэх салбарын дарга энэ журмын 8.1 дэх хэсэгт заасан хязгаарт багтаан томилж, түүнд "Итгэмжлэгдсэн ажилтан"-аар ажиллах үнэмлэх олгоно.

8.3. Сонгогчдын нэрийн жагсаалтын цахим болон цаасан хувилбартай танилцах, өөрчлөлт оруулах, сонгогчийн бүртгэлийг тулган шалгах үүрэг бүхий Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаас холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцын баталгаа гаргуулсан байна.

8.4. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 8.1 дэх хэсэгт заасан ажил үүргийн хуваарь, гэрээнд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй.

8.5. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан албан үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан, албан тушаалаа урвуулан ашигласан бол энэ журмын 8.2 дахь хэсэгт заасан албан тушаалтан гэрээг цуцлах эрхтэй.

#### **Ес. Бусад**

9.1. Сонгогчийн бүртгэлийн төхөөрөмжийг аймаг, дүүргийн бүртгэлийн хэлтэст хүргүүлэх, сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбарт лавлагааг үндэслэн өөрчлөлт оруулах, бүртгэлийн төхөөрөмжийг санал авах байранд хүргүүлэх, санал авах байранд санал авах өдөр хүртэл хадгалах, бүртгэлийн төхөөрөмжийг буцаан хүргэх үйл ажиллагаа нь цагдаагийн байгууллагын хамгаалалт, тагнуулын байгууллагын хяналтанд байна.


9.2. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах, сонгогч шилжих чиглэлээр гарсан улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын хуульд нийцсэн шийдвэрийг иргэд, аж ахуйн нэгж байгууллага биелүүлэх үүрэгтэй.

9.3. Сонгогчдын нэрийн жагсаалыг үйлдэхтэй холбогдуулан төрийн болон нутгийн захиргааны байгууллага улсын бүртгэлийн байгууллагад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

9.4. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгуулийн болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, улс төрийн намд сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой зөвхөн Сонгуулийн хуулинд заасан мэдээллийг гаргаж өгнө.

---oOo---

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



САНАЛ АВАХ БАЙРЫН ДЭРГЭД АЖИЛЛАХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТНЫ ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



Эцэг /эх/-ийн нэр:  
Өөрийн нэр:  
РД:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн ..... дугаар хэсгийн санал авах байрын дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан

(Төв хэсэгт ОӨУБЕГ-ын лого байна.)

Дугаар: 0001

Дугаар: 0001

Олгосон хугацаа:

2017 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дуусах хугацаа:

2017 оны ... дугаар сарын ... -ны өдөр


..... аймаг /нийслэл/-ийн  
Улсын бүртгэлийн хэлтэс /газар/-ын

Дарга ..... /..... /

5.5см

5.5см

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий  
газрын даргын 2017 оны 1293 дугаар  
тушаалын 3 дугаар хавсралт



### СОНГОГЧ ШИЛЖИХ ТУХАЙ ХҮСЭЛТ


2017 он ..... сар ..... өдөр

..... аймаг, хот ..... сум, дүүргийн .....  
дугаар баг, хорооны ..... байр, гудамжны .....  
тоотод оршин суугч .....-ны .....РД: .....  
миний бие ..... шалтгаанаар  
..... аймаг, хот руу явах болсон тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017  
оны ээлжит сонгуулийн ..... хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасч,  
шилжүүлэг олгож өгнө үү.

Хүсэлт гаргасан:


/ ..... /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын  
даргын 2017 оны А/2 дугаар  
тушаалын 4 дүгээр хавсралт



СОНГОГЧ ШИЛЖИХ ХУУДАС

<p>Дугаар ... -ний ... нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн ... дугаар хэсгээс ... шалтгааны улмаас шилжих хүсэлт гаргасан тул сонгогч шилжих хуудас олгов.</p> <p>Сонгогчийн:</p> <ul style="list-style-type: none"> <li>Регистрийн дугаар:</li> <li>Оршин суугаа газрын хаяг:</li> </ul> <p>Сонгуулийн хэсгийн ахлах зохион байгуулагч</p> <p>Тэмдэг</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>2017 оны ... сар ... өдөр</p> <p>/Иргэнд олгох/</p>	<p>Сонгогч шилжсэн тухай тэмдэглэл</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн ... дугаар хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын ... дугаараас хасав.</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>Тэмдэг</p> <p>2017 он ... сар ... өдөр</p> <p>Сонгогч шилжин ирсэн тухай тэмдэглэл</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн ... дугаар сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын ... дугаарт нэмж бүртгэв.</p> <p>Сонгуулийн ... дугаар хэсгийн ахлах зохион байгуулагч</p> <p>Тэмдэг</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>2017 оны ... сар ... өдөр</p> <p>/Иргэнд олгох/</p>
<p>СОНГОГЧ ШИЛЖИН ЯВСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ</p> <p>... овогтой ... /РД: /-г Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн ... дугаар сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын ... дугаарт бүртгэгдсэн бүртгэлээс хасч ... дугаартай сонгогч шилжих хуудас олгов.</p> <p>Сонгуулийн ... дугаар хэсгийн ахлах зохион байгуулагч</p> <p>Тэмдэг</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>(Улсын бүртгэлийн холбогдох байгууллагад үлдэх хувь)</p>	<p>СОНГОГЧ ШИЛЖИН ИРСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ</p> <p>... овогтой ... /РД: / нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн ... дугаар хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын ... дугаар бүртгэлээс хассан ... дугаар сонгогч шилжих хуудсыг үндэслэн ... дугаар хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын ... дугаарт бүртгэв.</p> <p>Сонгуулийн ... дугаар хэсгийн ахлах зохион байгуулагч</p> <p>Тэмдэг</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан</p> <p>/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/</p> <p>(Улсын бүртгэлийн холбогдох байгууллагад үлдэх хувь)</p>



Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 4/23 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ЛАВЛАГАА**

..... он ..... сар ..... өдөр

Үндсэн мэдээлэл:  
РД:  
Ургийн овог:  
Эцэг /эх/-ийн нэр:  
Нэр:  
Хүйс:  
Төрсөн огноо:  
Хаяг:

**Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан утга:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал өгөх: .....  
аймаг/дүүрэг/..... сум, хороо

Хэсгийн дугаар  
Сонгогчдын нэрийн жагсаалтад  
өөрчлөлт оруулах үндэслэл:

.....

..... аймаг /нийслэл, дүүрэг/-ийн  
ын  
Улсын бүртгэлийн  
хэлтэс /газар/-ийн дарга .....  
тэмдэг

..... сум /хороо/-  
улсын бүртгэгч  
.....  
тэмдэг

**Лавлагааг үндэслэн жагсаалтад нэмэлт, хасалт оруулсан:**


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн ..... дугаар хэсгийн улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан

Бар код

.....  
/Гарын үсэг/  
тайлал/

/Гарын үсгийн

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий  
газрын даргын 2017 оны 123 дугаар  
тушаалын 6 дугаар хавсралт



**БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

Эцэг /эх/-ийн нэр:

.....

Нэр:

.....

РД:

.....

Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн  
дугаар:

.....

..... аймаг/нийслэл/ .....  
сум/дүүрэг/-ын Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн  
хэсгийн дугаар:

.....









ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/294

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2202007691  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Д.Батбаатар /ХЗ78061817/-ын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-2202007691 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Хандгайтын 10 дугаар гудамжны 143 тоот хаягт байрлах хувийн сууцаа нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2202007691 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202007691 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000152955 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202007691 дугаартай хувийн хэрэгт бүртгэл болон цахим санд холбогдох бичилт хийж хаахыг Чингэлтэй дүүргийн улсын бүртгэл хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч Н.Энхцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Ганчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар

1/295

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2202015138  
дугаарыг хүчингүй болгож, Г-2202004252,  
Г-2202000437 дугаартай бүртгэлд  
нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн С.Давгадорж /ЧН78050677/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2202004252, Г-2202000437, Г-2202015138 дугаартай Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо, Хувьсгалчдын Г-11 дүгээр гудамжны 3а, 3б, 3г тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг шинэчлэн хийлгүүлсэн газрын кадастрын зургийн дагуу нэгтгэн бүртгүүлэхээр 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр мэдүүлэг гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2202015138 дугаарыг хүчингүй болгож хувийн хэргийг хаан, Г-2202004252, Г-2202000437 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2202004252, Г-2202000437, Г-2202015138 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000401629, 000401517, 000286726 дугаар гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2202015138 дугаартай хувийн хэрэг, бүртгэлийг хүчингүй болгож хаах, Г-2202004252, Г-2202000437 дугаарт бүртгэл хийж шинээр гэрчилгээ бичиж олгохыг Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Б.Сувд-Эрдэнэд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Ганчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар

А/296

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2206048626  
дугаарыг хүчингүй болгож, Y-2206048568  
дугаартай бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн А.Батсүх /ЧР62010272/-ын өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206048626 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Үйлдвэр Чингисийн өргөн чөлөө гудамж 77 а байрны 104 б тоот үйлчилгээний зориулалттай хэсгийг нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2206048626 дугаарыг хүчингүй болгож, Y-2206048568 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.


2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2206048626, Y-2206048568 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн 000531908, 000531914 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2206048626 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Y-2206048568 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Ж.Уранцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар

А/297

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2201018563,  
Y-2201012723 дугаарыг хүчингүй болгож хувийн  
хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Г.Баярцогт /ХЙ85070516/ нь эрхийн улсын бүртгэлийн Y-2201018563 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хороо, Зүүн баян уулын 11 дүгээр гудажны 15 тоот хаягт байрлах хувийн сууцаа буулгаж, нураасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2201018563 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Иргэн К.Гансүх /ЧВ56011018/ нь эрхийн улсын бүртгэлийн Y-2201012723 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо, Зүүн баян цагааны 12 дугаар гудажны 37 тоот хаягт байрлах хувийн сууцаа буулгаж, нураасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2201012723 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.


3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2201018563, Y-2201012723 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000001262, 0082153 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

4. Эрхийн улсын бүртгэлийн Y-2201018563, Y-2201012723 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Н.Бадрахцог-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн улсын ахлах бүртгэгч Г.Цолмон нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р. СОДХҮҮ



Хувийн хэрэг  
Хувийн хэрэг  
Хувийн хэрэг  
Хувийн хэрэг



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/298

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2201023442  
дугаарыг хүчингүй болгож хувийн  
хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Лопос” ХХК /Регистр №2809931/ нь эрхийн улсын бүртгэлийн Y-2201023442 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Дунд дүүрэн ам /18470/ Ф1 тоотод байрлах фермийн барилгаа буулгаж, өөр газар барьсан тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2201023442 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2201023442 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000104757 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2201023442 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч С.Батсүхд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн улсын ахлах бүртгэгч Г.Цолмон нарт тус тус дүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



Хүлэж авсан  
Хугацаа  
Эхний  
Хугацаа  
Хугацаа



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/299

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2206011735  
дугаарыг хүчингүй болгож, Г-2206003149 дугаартай  
бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Г.Энхсайхан /ПК87062214/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2206011735 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Буянт-Ухаа 19 дүгээр гудамжны 684В тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг эрхийн улсын бүртгэлийн Г-2206003149 дугаарт бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Буянт-Ухаа 19 дүгээр гудамжны 684Б тоот хаягтай гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газартай нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2206011735 дугаарыг хүчингүй болгож, Г-2206003149 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2206011735, Г-2206003149 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн 000388346, 000064261 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2206011735 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Г-2206003149 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Н.Батсүхэд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

Бүртгэлийн тасгийн дарга  
Хүндэтгэсэн  
Хүндэтгэсэн  
Хүндэтгэсэн  
Хүндэтгэсэн



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/300

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Х.Дуламсүрэнгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хүний нөөц, сургалтын хэлтсийн мэргэжилтэн Төмөртоогогийн Наранцэцэгийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Наранцэцэгт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар

А/301

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-0614006285,  
Г-0614014993 дугааруудыг хүчингүй болгож, хувийн  
хэрэг, улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Б.Баттөмөр /ЧС57012519/-ийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0614006285 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 3 дугаар баг, Бумбат а0 гудамжны 01 тоот, мөн эрхийн улсын бүртгэлийн Г-0614014993 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 3 дугаар баг, Бумбат а0 гудамжны 01а тоот хаягт тус тус байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрх Дорнод аймгийн Засаг даргын 2016 оны А/120 тоот захирамжаар дуусгавар болсон байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-0614006285, Г-0614014993 дугааруудыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-0614006285, Г-0614014993 дугааруудыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000327354, 000290338 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-0614006285, Г-0614014993 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Наранжаргалд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбаяр нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар

А/302

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1. иргэн С.Рагчаа /ПЮ58102866/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-1617001552 дугаарт бүртгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт баг, 02 дугаар гудамжны 08 тоот хаягт байрлах, хувийн сууцны 000150058 дугаартай;

1.2. иргэн Д.Долгоржав /ПВ69020802/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-1617000604 дугаарт бүртгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сумын Алагтолгой баг, 02 дугаар гудамжны 286 тоот хаягт байрлах, хувийн сууц, ажлын байрны 000079323 дугаартай;


1.3. иргэн Д.Наранцэцэг /ПЯ66062569/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-1617000967 дугаарт бүртгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сум, Жаргалан баг, 05 дугаар арван жилийн баруун талд байрлах, 2 давхар үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн 0018501 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг одон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/303

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай:

1.1.иргэн Ц.Баасан /ЙИ73092312/, П.Цэрэнлхам /ЙЭ49042101/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-1018002766 дугаарт бүртгэлтэй, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 4 дүгээр баг, 1а гудамжны 46 тоот хаягт байрлах, хувийн сууцны зориулалттай 000134878 дугаартай;

1.2.иргэн Ц.Баасан /ЙИ73092312/, П.Цэрэнлхам /ЙЭ49042101/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1018002418 дугаарт бүртгэлтэй, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 4 дүгээр баг, 1а гудамжны 46 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000135007 дугаартай;

1.3.иргэн Д.Дашсүрэн /ТВ50070145/, Д.Хаш-Эрдэнэ /ТВ50111011/, Х.Энхзаяа /ТА89071502/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2003009808 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар баг, Ханжаргалант 3 дугаар гудамжны 99 тоот хаягт байрлах, худаг, хувийн сууцны зориулалттай 000101461 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/304

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-0320000632.  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Баянхонгор аймгийн Хяналтын улсын байцаагчийн 000113 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. иргэн Б.Оюунцэцэг /ВЭ62120909/-ийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-0320000632 дугаарт бүртгэлтэй, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 7 дугаар багт байрлах, хувийн сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн эрхийн улсын бүртгэлийн Y-0320000632 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-0320000632 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 0014695 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-0320000632 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Баярмаад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар

А/305

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-1018006601  
дугаарыг хүчингүй болгож, Г-1018006196  
дугаартай бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Иргэн Т.Долгорсүрэн /ИИ72120105/ нь эрхийн улсын бүртгэлийн Г-1018006601 дугаарт бүртгэлтэй, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, 10 дугаар баг, Ноён 53 дугаар гудамжны 14а тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг, эрхийн улсын бүртгэлийн Г1018006196 дугаарт бүртгэлтэй Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, 10 дугаар баг Ноён 53 дугаар гудамжны 14 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газартай нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-1018006601 дугаарыг хүчингүй болгож, эрхийн улсын бүртгэлийн Г-1018006196 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-1018006601 дугаарыг хүчингүй болгож Г-1018006196 дугаартай бүртгэлд нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000445143,00224562 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-1018006601 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Г-1018006196 дугаарт нэгтгэж бүртгэсэн эд хөрөнгөд шинээр гэрчилгээ олгохыг Өвөрхангай аймгийн Улсын бүртгэл хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Эрдэмзаяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга З.Буянбадрах нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар

А/306

Улаанбаатар хот

Бүртгэл хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, хяналтын улсын байцаагчийн 2017 оны 571 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Даваабаяр нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг, Хүрэнбулаг 10 дугаар байрны ард байрлах гражийн зориулалттай эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөр иргэн В.Ганзоригийг 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдөр нэмж, эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулахдаа Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.5, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийг тус тус зөрчсөн болох нь тус газрын Хяналтын газрын хяналт шалгалтаар тогтоогдож байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2101017174 дугаарт бүртгэлтэй эд хөрөнгийн бүртгэлд 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдөр оруулсан өөрчлөлтийг хүчингүй болгосугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2101017174 дугаарт бүртгэлтэй эд хөрөнгийн бүртгэлд 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдөр оруулсан өөрчлөлтийг хүчингүй болгосонтой холбогдуулан улсын бүртгэлийн 000534080 дугаартай гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Мөнхболд, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА, УЛСЫН  
ЕРӨНХИЙ БҮРТГЭГЧ

Р.СОДХҮҮ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
АКТ**

14171 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Цагдаагийн гудамж, Утас: 351245, Факс: (976-11) 351245  
<http://www.burtgel.gov.mn>

**2012.03.22 № 521**

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ

Бүртгэл хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, Улсын бүртгэлийн хяналтын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, Оюуны өмч, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

1.Иргэн Д.Буянхүүгээс тус газарт хандан «Миний бие Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг, Хүрэнбулаг 10 дугаар байр, байрны ард байрлах 216 кв талбай бүхий гражийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг 2014 оноос эхлэн хууль ёсны дагуу өмчилж байгаа билээ.

Гэтэл Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Даваабаяр нь 2017 оны 3 дугаар сарын 10-ны өдөр миний төрсөн ах болох Лхамхүүтэй утсаар холбогдож улсын бүртгэлийн гэрчилгээгээ авчрах хэрэгтэй байна.

Учир нь эд хөрөнгийн бүртгэл устсан тул хэрэг болоод байна хэмээн хэлж хууран мэхэлж улсын бүртгэлийн 000235750 дугаартай гэрчилгээг авсан.

Ийнхүү үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээг худал хэлж авч Викторын Ганзоригийг улсын бүртгэлийн гэрчилгээн дээр миний зөвшөөрөлгүйгээр хамтран өмчлөгчөөр нэмж оруулан 000534080 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээг гаргаж олгосон ба миний өмчлөх эрхийг баталгаажуулсан 000235750 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосон байна.

Энэхүү улсын бүртгэгчийн үйлдэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийг ноцтойгоор зөрчсөн үйл ажиллагаа боллоо.

Иймд уг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Даваабаярын хууль зөрчиж бүртгэсэн бүртгэлийг хүчингүй болгож, эрхийг минь сэргээж, улсын бүртгэлийн Y-2101017174 дугаарт бүртгэгдсэн 000235750 дугаартай гэрчилгээг дахин хэвлэж өгөхийг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст даалгаж өгнө үү» гэх гомдлын дагуу хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.1.Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг, Хүрэнбулаг 10 дугаар байр, байрны ард байрлах гражийн зориулалттай эд хөрөнгө нь анх 2014 оны 2 дугаар сарын 19-ний өдөр иргэн Д.Буянхүү /ФБ70092028/-ийн

өмчлөлд эрхийн улсын бүртгэлийн Ү-2101017174 дугаарт бүртгэгдэн, улсын бүртгэлийн 000235750 дугаартай гэрчилгээ олгогдсон байна;

1.2. Уг эд хөрөнгийн өмчлөлд 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдөр өөрчлөлт оруулан хамтран өмчлөгчөөр иргэн В.Ганзориг /АГ72090239/-ийг нэмж бүртгэн, 000534080 дугаартай гэрчилгээг олгосон байна.

Уг бүртгэлийг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Даваабаяр бүртгэсэн байна.

Ийнхүү бүртгэж, гэрчилгээ олгохдоо иргэн В.Ганзоригийн өргөдлийг үндэслэсэн байна. Иргэн В.Ганзоригийн өргөдөлд:

Миний бие В.Ганзориг нь Орхон аймгийн Хүрэнбулаг багийн 10 дугаар байрны ард байрлах машины 10 гражийн газрыг Д.Буянхүүгийн хамт дуудлага худалдаанд орж, уг газрын эзэмших эрхийг хамтран эзэмшигчээр орж байсан бөгөөд Д.Буянхүү уг гражийн газрыг дангаар эзэмших гэрчилгээ авчээ.

Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.10-д зааснаар газар эзэмшүүлэх эрх, гэрчилгээ олгохдоо газар эзэмших болсон үндэслэл, дуудлага худалдааны бичиг баримтыг үндэслэхгүйгээр ганц Буянхүүд эзэмших эрхийн гэрчилгээ олгон, уг газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө болох 10 машины гражийг мөн Буянхүүг өмчлөгчөөр бүртгэсэн гэрчилгээ олгожээ.

Энэ нь газрын тухай хуулийн болон улсын бүртгэлийн тухай хуулийн зохих зүйл, заалтыг зөрчсөн байна гэж үзэж байна.

Иймд уг үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэсэн бүртгэлийг дахин үзэж, уг гэрчилгээг хүчингүй болгож өгнө үү» гэжээ.

1.3. Улсын бүртгэгч Б.Даваабаяр тус газарт хандан гаргасан тайлбартаа «Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Даваабаяр миний бие 2014 онд иргэн Д.Буянхүүгийн хүсэлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийг улсын бүртгэлийн Ү-2101017174 дугаарт бүртгэж, 000235756 дугаартай гэрчилгээ олгосон.

Харин 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдөр иргэн В.Ганзориг манай байгууллагад хандан хүсэлт гаргаж газрын гэрчилгээн дээр хамтран өмчлөгчөөр миний нэр бичээстэй байхад ганцхан Д.Буянхүүгийн нэрээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргасан байна.

Иймд намайг давхар бүртгэж өгнө үү гэсэн хүсэлтийн дагуу уг бүртгэлийг алдаатай бүртгэсэн болохыг мэдсэн. 2017 оны 3 дугаар сарын 10-ны өглөө ажилдаа ирэхэд Тасгийн дарга С.Жамбалсүрэн дуудаж, алдаатай бүртгэл хийсэн байна, иймд иргэн В.Ганзоригийн асуудлыг шийдэж өг гэсэн.

Тиймээс иргэн Д.Буянхүүгээс гэрчилгээг хураан авч хүчингүй болгож бүртгэгчийн алдаа болгож дахин шинэ гэрчилгээг иргэн В.Ганзоригийн хүсэлтийг үндэслэн нэрийг нь оруулан бичиж өгсөн.

Гэвч дахин гэрчилгээ бичихдээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 7.4 дэх заалтыг тус тус зөрчиж иргэн Д.Буянхүүгээс зөвшөөрөл авалгүй дахиж алдаатай бүртгэл хийж ажлын хариуцлага алдсан болно.

Одоогоор үл хөдлөх эд хөрөнгийн эх хувь гэрчилгээг хэнд ч өгөөгүй бөгөөд хувийн хэрэгт нь түр хадгалж байгаа» гэжээ.

1.4.Орхон аймаг дах Сум дундын Иргэний хэргийн Анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 142/Ш32016/03817 дугаартай захирамжаар Y-2101017174 дугаарт бүртгэлтэй, Хүрэнбулаг багт байрлах гражийг . . . хэргийг хянан шийдвэрлэтэл битүүмжилж, битүүмжлэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар хэрэгжүүлэхээр заасан байна.

Энэхүү захирамжийн дагуу Y-2101017174 дугаарт бүртгэлтэй эд хөрөнгийн бүртгэлд тусгай тэмдэглэл хийсэн нь Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад заасан « Шүүх, арбитр, . . . байгууллагаас өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарласан шийдвэр гарсан» гэж заасантай нийцэж байна.

2.Эрхийн улсын бүртгэлийн Y-2101017174 дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг, Хүрэнбулаг 10 дугаар байр, байрны ард байрлах гражийн зориулалттай эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөр иргэн В.Ганзоригийг нэмж, эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулан бүртгэхдээ Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д «Эрхийн улсын бүртгэл үнэн зөв . . .», 7.3-т « Иргэний хуулийн 183.2-т заасны дагуу бүртгүүлэх эрхгүй этгээдийн нэрээр хийлгэсэн бүртгэлийн үр дүнд эрх болон эрх зүйн байдлын хувьд хохирч байгаа этгээд бүртгэлд нэр нь байгаа этгээдээс эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг шаардсаныг уг этгээд хүлээн зөвшөөрсөн бол энэ тухай баримтыг үндэслэн ерөнхий бүртгэгчийн шийдвэрээр эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулж болно», 7.4-т «Энэ хуулийн 7.3-т заасан шаардлагыг эрхийн улсын бүртгэлд нэр байгаа этгээд зөвшөөрөөгүй бол шүүхийн шийдвэр гарсны дараа эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна», 7.5-д «Иргэний хуулийн 183.3-д заасны дагуу эрхийн улсын бүртгэл буруу ташаа болох тухай өргөдлийг эрх нь зөрчигдөж байна гэж үзсэн этгээд эрхийн улсын бүртгэлийн төрийн захиргааны байгууллагад гаргах эрхтэй бөгөөд өргөдлийг шалгах явцад эрхийн улсын бүртгэл буруу хийгдсэн нь тогтоогдвол ерөнхий бүртгэгчийн шийдвэрээр өөрчлөлт оруулж болно», 20.5-д «энэ хуулийн 20.1.4-т заасан үндэслэлээр тусгай тэмдэглэл хийсэн бол өмчлөгчийн эрхийг хязгаарласан этгээдийн шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна» гэж тус тус заасныг зөрчсөн байх тул ДҮГНЭХ нь:

2.1.Эрхийн улсын бүртгэлийн Y-2101017174 дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг, Хүрэнбулаг 10 дугаар байр, байрны ард байрлах гражийн зориулалттай эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөр

2.1. Эрхийн улсын бүртгэлийн Ү-2101017174 дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг, Хүрэнбулаг 10 дугаар байр, байрны ард байрлах гражийн зориулалттай эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөр иргэн В.Ганзоригийг нэмж, эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулан бүртгэснийг ОӨУБЕГ-ын дарга бөгөөд Ерөнхий бүртгэгчийн шийдвэрээр хүчингүй болгох;

2.2. Эрхийн улсын бүртгэлийн Ү-2101017174 дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг, Хүрэнбулаг 10 дугаар байр, байрны ард байрлах гражийн зориулалттай эд хөрөнгийн хамтран өмчлөгчөөр иргэн В.Ганзоригийг нэмж, эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулан бүртгэснийг ОӨУБЕГ-ын дарга бөгөөд Ерөнхий бүртгэгчийн шийдвэрээр хүчингүй болгосонтой холбогдуулан эрхийн улсын бүртгэлийн 000534080 дугаартай гэрчилгээг хүчингүйд тооцох;

2.3. Ажлын хариуцлага алдсан, албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Даваабаярт Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах саналыг ОӨУБЕГ-ын даргад уламжлах.

ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГАСЫН АХЛАХ  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

ХЯНАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ  Б.ГАНЗОРИГ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/307

Улаанбаатар хот

Томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говьсүмбэр, Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаанд шалгалт хийх зорилгоор Хяналтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Б.Ганбаатар, хяналтын улсын байцаагч Б.Галбадрах, Л.Баатар, Д.Чинтулга, жолооч Н.Пүрэвжамц нарыг 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 03-ны өдрийг дуусталх хугацаанд албан томилолтоор ажиллуулсугай.

2. Говьсүмбэр, Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг шалгах ажлын удирдамжийг нэгдүгээр, томилолтоор ажиллах зардлын тооцоог хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Томилолтоор ажиллах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Тамгын газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.

4. Томилолтоор ажилласан тайланг 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр танилцуулахыг Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 7-р дугаар тушаалын хавсралт

### АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Ажиллах албан хаагчийн тоо	Нэг хоногийн зардал /төгрөгөөр/	Нийт зардлын дүн /төгрөгөөр/
1	Томилолтын зардал /5 хоног/	4	29.000	580.000
2	Томилолтын зардал /5 хоног/	1	14.000	70.000
3	Шатахууны зардал /Улаанбаатар-Говьсүмбэр-Дорноговь-Улаанбаатар/	940 км х 0.21х1800		355.320
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>1.005.320</b>

----oOo----

БАТЛАВ: ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Р.СӨДХҮҮ

ГОВЬСҮМБЭР, ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХИЙХ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

2017.03.28

Улаанбаатар хот

#### **Нэг. Шалгалтын зорилго**

1.1 Энэхүү шалгалтын зорилго нь Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2016-2017 онуудад бүртгэсэн улсын бүртгэлийн үйл ажиллагаа улсын бүртгэлийн хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд 2016 онд хийсэн төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчил арилсан эсэх, 2017 онд бүртгэсэн бүртгэлийн үйл ажиллагаа улсын бүртгэлийн хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулахад оршино.

#### **Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн**

2.1 Шалгалтыг Хяналтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Б.Ганбаатар, хяналтын улсын байцаагч Б.Галбадрах, Л.Баатар, Д.Чинтулга нарын бүрэлдэхүүнтэйгээр 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 03-ны өдрийг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

#### **Гурав. Шалгалтын хамрах хүрээ**

3.1. Шалгалтаар 2016 оны төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэл, 2017 онд бүртгэж баталгаажуулсан Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг шалгана.

#### **Дөрөв. Шалгалтын чиглэл**

##### **4.1 Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- 4.1.1 Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа;
- 4.1.2 Иргэний цахим үнэмлэх олголтын үйл ажиллагаа;
- 4.1.3 Үнэт цаасны зарцуулалт;

##### **4.2. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:**

- 4.2.1 Анхны бүртгэл хөтлөх үйл ажиллагаа;
- 4.2.2 Гэрээний эрхийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа;

4.2.3 Барьцааны гэрээ;

4.2.4 Үйлчилгээний, тэмдэгтийн, татварын хураамж төлөлтийн байдал;

4.1.5 Үнэт цаасны зарцуулалт;

**4.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

4.3.1 Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа;

**4.4. Үнэт цаасны зарцуулалт;**

**4.5. Архивын үйл ажиллагаа;**

**4.6. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа;**

**Зургаа. Шалгалтын дүнгийн талаар:**

5.1. Шалгалтын талаар тайлан бичиж, дүнг шалгалт дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга бөгөөд Улсын ерөнхий байцаагчид илтгэх хуудсаар танилцуулна.

5.2. Шалгалтын мөрөөр илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

---oOo---

ХЯНАСАН:  
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА



Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:  
ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ



Б.ГАНБААТАР



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/308

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай:

1.1. Иргэн Ш.Одонтуяа /АЮ82082101/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2102000395 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Жаргалант сумын Жаргалант баг 2 дугаар байрны 17 тоот хаягт байрлах орон сууцны 000190815 дугаартай;

1.2. Иргэн М.Гэрэлмандах /ФМ62021044/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2101002538 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4 дүгээр баг Хүрэнбулаг 4 дүгээр хороолол 18 дугаар байрны 82 тоот хаягт байрлах орон сууцны 000359267 дугаартай;

1.3. Ц.Цэрэннадмид /НФ68022611/, Ч.Сайнбат /ЧЙ68080361/, Ц.Цэвэлсүрэн /НФ91012601/, Ц.Гунгаа /НФ92092138/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-1424000038 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Эрдэнэсант сумын 5 дугаар баг 5 дугаар байр 3 тоот хаягт байрлах орон сууцны 0068271 дугаартай;

1.4. Б.Төрбат /Нь67091875/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1402000443 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Аргалант сумын 2 дугаар баг Хөшөөт цагаан хөтөл 1-54 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000341374 дугаартай;

1.5. С.Баттулга /ЧЛ83062515/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1423001226 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Эрдэнэ сумын 3 дугаар баг Баянтуул суурин 6 дугаар тойрог 623 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000283236 дугаартай;

1.6. С.Баттулга /ЧЛ83062515/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1423001228 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Эрдэнэ сумын 3 дугаар баг Баянтуул суурин 6 дугаар тойрог 626 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000283237 дугаартай;

1.7. С.Баттулга /ЧЛ83062515/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1423001231 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Эрдэнэ сумын 3 дугаар баг Баянтуул

суурин 6 дугаар тойрог 622 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000283238 дугаартай;

1.8. С.Баттулга /ЧЛ83062515/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1423001233 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Эрдэнэ сумын 3 дугаар баг Баянтуул суурин 6 дугаар тойрог 625 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000283239 дугаартай;

1.9. С.Баттулга /ЧЛ83062515/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1423001234 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Эрдэнэ сумын 3 дугаар баг Баянтуул суурин 6 дугаар тойрог 624 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000283240 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/309

Улаанбаатар хот

Г Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 5.11, 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцугай. Үүнд:

1.1. Иргэн М.Сосорбарам /НТ85012109/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204020601 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо, Шархад 61 дүгээр гудамж, 895 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000259941 дугаартай;

1.2. Иргэн М.Сосорбарам /НТ85012109/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204075013 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороо, Шархад 61 дүгээр гудамж, 895 тоот хувийн сууцны 000462327 дугаартай;

1.3. Иргэн М.Энхүүн /УХ89042982/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206029498 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Вива сити, 3/26 дугаар байрны 5-2 тоот орон сууцны 000290695 дугаартай;

1.4. Иргэн Г.Жавхлантөгс /ДК81020515/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206034034 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо, Үйлдвэр, Туул гол гудамж, 81/А дугаар байрны 4 тоот орон сууцны 000344531 дугаартай;

1.5. Иргэн Д.Эрдэнэбилэг /УС64022027/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206006205 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, Нэхмэлийн 11 дүгээр байрны 8 тоот орон сууцны 000114290 дугаартай;

1.6. Иргэн М.Төгөлдөр /ХГ82032070/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206047056 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, 5 дугаар хэсэг гудамж, 569 тоот хувийн сууцны 000505772 дугаартай;

1.7. Иргэн М.Төгөлдөр /ХГ82032070/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206047055 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, 5 дугаар хэсэг гудамж, 568 тоот хувийн сууцны 000505771 дугаартай;

1.8. Иргэн Д.Рэнцэнпүрэв /ЙО75102312/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2207002568 дугаарт бүртгэлтэй, Налайх дүүргийн 1 дүгээр хороо, Энгэршанд 21 дүгээр гудамж, 12 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 371101 дугаартай;

1.9. Иргэн Г.Отгонбаяр /УД74080784/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2207000707 дугаарт бүртгэлтэй, Налайх дүүргийн 2 дугаар хороо, Цагдаагийн 5 дугаар гудамж, 14 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 43885 дугаартай.

2. Багахангай, Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 104/ШШ2016/00459 дугаар шүүгчийн шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 1977 дугаар магадлал, Багахангай, Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 104/ШЗ2017/00126 дугаар шүүгчийн захирамж, Налайх дүүрэг дэх шийдвэр гүйцэтгэлийн хэсгийн 1/288 тоот албан бичгийг тус тус үндэслэн иргэн С.Батцэнгэл /УД92061215/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2207004765 дугаарт бүртгэлтэй, Налайх дүүргийн 2 дугаар хороо, 66 дугаар байрны 06 тоот орон сууцны 000462766 дугаартай.

3. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 9/310

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2204015764 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн К.Кенженбек /XA74111576/-ын эрхийн улсын бүртгэлийн Y-2204015764 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо Сэлбийн 63 дугаар гудамжны 389 тоот хувийн сууцны зориулалттай барилгаа нурааж, буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2204015764 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, улсын бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204015764 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000214219 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204015764 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ш.Энхцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

Баянзүрх дүүргийн  
Улсын бүртгэлийн  
Хэлтсийн  
Эд хөрөнгийн  
эрхийн бүртгэлийн  
Тасгийн дарга  
М.Батцэцэг  
2017.03.29



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар

А/311

Улаанбаатар хот

Г Эрхийн улсын бүртгэлийн Г-2204027532 Г  
дугаарыг хүчингүй болгож, Г-2204011933  
дугаартай бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн С.Адъяацэрэн /кю81051020/-гийн өөрийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-2204027532, Г-2204011933 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, Өлгий 12 дугаар гудамжны 188а, 188б тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2204027532 дугаарыг хүчингүй болгож, Г-2204011933 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204027532, Г-2204011933 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн 000419435, 000259655 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204027532 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Г-2204011933 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн бүртгэгч Ш.Энхцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/312

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2102000126 дугаарын тусгай тэмдэглэлд өөрчлөлт хийх, Y-2102000125 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах заалт, хяналтын улсын байцаагчийн 2017 оны 579 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрхийн улсын бүртгэлийн Y-2102000126 дугаарт бүртгэлтэй Орхон аймгийн Жаргалант сумын Жаргалант багийн нутагт байрлах "Жаргалант-Үйлс" ХК-ийн өмчлөлд бүртгэлтэй үйлдвэр худалдааны зориулалттай барилгыг эрхийн улсын бүртгэлийн Y-2102000125 дугаарт давхардуулан бүртгэсэн нь Хяналтын газрын хяналт шалгалтаар тогтоогдож байх тул Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2102000125, 2102000126 дугааруудад Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2009 оны 445 дугаар тушаалаар бүртгэлийн хөдөлгөөн түдгэлзүүлснийг цуцалж, хөдөлгөөн сэргээсүгэй.

2. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3-т заасны дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2102000125 дугаарыг хүчингүй болгож, давхардуулан бүртгэсэн хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2102000125 дугаартай хувийн хэрэг, бүртгэлийг хүчингүй болгож, хааж байгаатай холбогдуулан үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн 0052288 дугаартай гэрчилгээг хүчингүйд тооцсугай.

4. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим сан /ePRS/-д эрхийн улсын бүртгэлийн Y-2102000125 дугаартай бүртгэлийг хүчингүй болгохыг Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэнд зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Мөнхболд, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА, ЕРӨНХИЙ БҮРТГЭГЧ

Р.СОДХҮҮ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ**

14171 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Цагдаагийн гудамж, Утас: 351245, Факс: (976-11) 351245  
<http://www.burtgel.gov.mn>

2017.03.23 № 579

ОРХОН АЙМГИЙН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ЭД  
ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН  
ТАСАГТ

Тусгай тэмдэглэлд өөрчлөлт хийж,  
давхар бүртгэлийг хаах тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 10.5, Улсын бүртгэлийн хяналтын дүрмийн 2.1.3, Оюуны өмч, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журмын 22.1-дэх заалтыг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн эрхийн улсын бүртгэлийн Y-2101005405 Б дугаарт бүртгэлтэй Орхон аймгийн Жаргалант сумын Жаргалант багийн нутагт байрлах 1000 мкв талбайтай 208 м 60 тонны мах хадгалах зоорьтой 1820 мкв үйлдвэр худалдааны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн тусгай тэмдэглэлд өөрчлөлт оруулах, дээрх үл хөдлөх эд хөрөнгийг эрхийн улсын бүртгэлийн Y-2101005405 А дугаарт давхар бүртгэл хийж, эрхийн улсын бүртгэлийн 0052288 дугаартай гэрчилгээ олгогдсон байх тул бүртгэлийг хааж шийдвэрлэнэ үү гэсэн албан бичгийн дагуу хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1. Эрхийн улсын бүртгэлийн Y-2102000125, Y-2102000126 дугааруудад Орхон аймгийн Жаргалант сумын Жаргалант багийн нутагт байрлах үйлдвэр худалдааны зориулалттай барилгын өмчлөгчөөр "Жаргалант-Үйлс" ХК бүртгэлтэй байна.

2. Орхон аймгийн цагдаагийн хэлтсээс 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн улсын бүртгэлийн хэлтэст ирүүлсэн "Жаргалант-Үйлс" ХК-ны үйлдвэр худалдааны барилгыг хуурамч нотлох баримт бүрдүүлж давхардуулан өмчлөлд бүртгүүлсэн байж болзошгүй бүртгэлийг шалгуулахаар хандсаныг архивт шүүж байхгүй тухай албан бичиг, мөн аймгийн прокурорын газраас ирүүлсэн 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн албан бичигт эрхийн улсын бүртгэлийг түдгэлзүүлсэнтэй холбоотой хүсэлт, эрх бүхий байгууллагын шийдвэр байхгүй тухай албан бичигтэй байна.

3. Бүртгэлийн хяналтын газраас 2009 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Орхон аймгийн засаг даргын дэргэдэх цагдаагийн газарт хандан эрхийн улсын бүртгэлийн Y-2101005405А, Y-2101005405Б дугаарт үйлдвэр худалдааны барилгыг

"Жаргалант-Үйлс" ХК-ны өмчлөлд бүртгэснийг шалгуулах тухай албан бичиг, мөн иргэн Н.Мөнхтуяа, Ж.Амаржаргал нарын гаргасан өргөдлийн хариуд Улсын ерөнхий бүртгэгчийн тушаалаар дээрх эрхийн бүртгэлийг 2009 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр түдгэлзүүлэн, хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн тухай албан бичиг хувийн хэрэгт авагдсан байна.

4. Зоос банкны эрх хүлээн авагч Монгол банкнаас Улсын бүртгэлийн ерөнхий газрын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт хандан "Жаргалант-Үйлс" ХК-ны эрхийн улсын бүртгэлийн 2101005405 А дугаартай үл хөдлөх хөрөнгө нь /0052288 гэрчилгээний дугаар бүхий/ 2013 оны 04 дүгээр сарын 02-ны байдлаар ноогдох үүрэг хангагдсан тул барьцаанаас чөлөөлсөн тухай албан тооттой байна.

5. Орхон аймгийн захиргааны хэргийн шүүхийн 2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 102 дугаартай захирамжийн ЗАХИРАМЖЛАХ нь хэсэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасныг баримтлан Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст холбогдох "Жаргалант-Үйлс" ХК-ны гүйцэтгэх захирал Н.Мөнхтуяагийн "Жаргалант-Үйлс" ХК-ны үл хөдлөх эд хөрөнгийн 0052288 дугаартай гэрчилгээтэй, 2101005405 дугаарт бүртгэгдсэн бүртгэлийг хүчингүй болгуулах"-ыг хүссэн хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.

6. Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 399 дугаартай шийдвэрийн ҮНДЭСЛЭХ нь хэсэгт "Жаргалант-Үйлс" ХК-ны шинэчилсэн дүрмийн дагуу 2012 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр уг компанийн гүйцэтгэх захиралаар Н.Үржинцогийг томилсныг бүртгэсэн тухай улсын бүртгэлийн лавлагаа, гэрчилгээ, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 5/1969 дүгээр албан бичиг зэргийг үзвэл 2013 оны 5 дугаар сарын 24-ны өдөр "Жаргалант-Үйлс" ХК-ийг төлөөлж Н.Үржинцог шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзээд холбогдох нотлох баримтуудыг үнэлэн 2011 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Сангийн яаманд хүргүүлсэн лавлагаанд "Жаргалант-Үйлс" ХК-ийн дээрх үйлдвэр, худалдааны барилгыг давхардуулан бүртгэсэн болохыг хүлээн зөвшөөрсөн байх тул шүүхээс энэ талаар тусгайлан дүгнэлт гаргах шаардлагагүй гэж үзсэн байна. Мөн шийдвэрийн ТОГТООХ нь хэсэгт Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг баримтлан "Жаргалант-Үйлс" ХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.

7. Аймгийн Эд хөрөнгийн бүртгэлийн тасагт дээрх компанийн хувийн хэргийг цахимжуулах үед хаягийг Баян-Өндөр сум гэж буруу төлөв оноосон тул эрхийн улсын бүртгэлийн Ү-2102000125 дугаар нь 2101005405А дугаарт, Ү-2102000126 дугаар нь 2101005405Б бүртгэлийн дугаарт шилжсэн байна. Дээрх нотлох баримтуудыг үндэслэн улсын бүртгэлийн зөрчлийг арилгах зорилгоор ДҮГНЭХ нь:

1. Эрхийн улсын бүртгэлийн Ү-2102000126 /2101005405Б/ дугаарт бүртгэлтэй Орхон аймгийн Жаргалант сум Жаргалант багийн нутаг дэвсгэрт байрлах үйлдвэр, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн

бүртгэлд тусгай тэмдэглэл хийснийг Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасныг баримтлан эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах,

2. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3-т заасныг баримтлан Эрхийн улсын бүртгэлийн Y-2102000125 /Y-2101005405A/ дугаартай бүртгэлийг хааж, давхардуулан олгосон 0052288 дугаартай үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг Улсын ерөнхий бүртгэгчийн тушаалаар хүчингүй болгохоор дүгнэв.

ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Б.ГАНБААТАР

Д.ЧИНТУЛГА





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/313

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2204031918 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Б.Хүрэлсүх /УВ86012736/ нь эрхийн улсын бүртгэлийн Y-2204031918 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо, Бага Дарь Эхийн 6 дугаар гудамжны 1288 тоот хаягт байрлах хувийн сууцны зориулалттай барилгыг нураасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2204031918 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204031918 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000122318 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204031918 дугаартай хувийн хэрэг, Бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Г.Чанцалдиймаад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

Бөгөөд үүнийг  
МОНГОЛ  
ХУУЛЬ  
Хүндэтгэсэн



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар

А/314

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Г.Мөнхбатын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Сайнтуяагийн Одгэрэлийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Одгэрэлд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар

A/315

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай:

1.1. иргэн Б.Цэцэг-Эрдэнэ /АЭ79100202/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-1301000724 дугаарт бүртгэлтэй, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 2 дугаар баг, 1 дүгээр гудамжны 12 тоот хаягт байрлах, хувийн сууц, гаражийн зориулалттай 000189252 дугаартай;

1.2. иргэн М.Энхмандах /ДЮ88021319/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2003014045 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багт байрлах, үйлдвэрлэлийн зориулалттай барилгын 000536553 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/316

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай:

1.1.иргэн Ц.Доржханд /ИС86081701/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1018006404 дугаарт бүртгэлтэй, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 10 дугаар баг, 24 дүгээр гудамжны 4 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000274788 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Эрдэмзаяад зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

В.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/317

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай:

1.1. иргэн Б.Даваасүрэн /М080052600/, Ч.Отгонжаргал /УС82032752/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1316001785 дугаарт бүртгэлтэй, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр баг, Дээж гудамжны 4-4 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000013991 дугаартай;

1.2. иргэн С.Мөнхцэцэг /ГИ58050100/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2001000455 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Хайрхан баг, 12 дугаар байрны 54 тоот хаягт байрлах орон сууцны зориулалттай 000125767 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

Handwritten notes and stamps at the bottom right of the page.



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 09 сарын 31 өдөр

Дугаар #/318

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002769 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн С.Ганбат /ПК77090711/-ын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1617002769 дугаарт бүртгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сум, 1 дүгээр баг, Алтантолгой багийн 1 дүгээр гудамжны 43 тоот хаягт байрлах хувийн сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-1617002769 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.
2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002769 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000182993 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.
3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1617002769 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Хишигзаяад зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/319

Улаанбаатар хот

Ашигтай загварыг бүртгэж,  
гэрчилгээ олгох тухай

Монгол улсын "Патентийн тухай хууль"-ийн 12, 14 дүгээр зүйл, шинжээчийн магадлан дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэрчилгээ олгох шалгуур хангасан 20 ашигтай загварыг улсын бүртгэлд бүртгэсүгэй.
2. Улсын бүртгэлд бүртгэсэн ашигтай загваруудыг хавсралтаар баталсугай.
3. Ашигтай загварын эзэмшигчдэд гэрчилгээ олгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2017 оны 189 дугаар тушаалын хавсралт

Гэрчилгээ олгох шалгуур хангасан ашигтай загварын жагсаалт

No.	Гэрчилгээний дугаар	Ашигтай загварын нэр	Анхдагч огноо	Эрх эзэмшигч
1	2665	Хонины гурван шимт яснаас эрдсийн бэлдмэл үйлдвэрлэх арга	2016-11-04	Н.Чимэгээ, Л.Түмэндэмбэрэл
2	2666	Ямааны утаж хатаасан мах үйлдвэрлэх арга	2016-11-04	Н.Чимэгээ, Н.Хишигжаргал, Л.Дамдинсүрэн,
3	2667	Хаягдалаар блок үйлдвэрлэх арга, түүний найрлага	2016-11-11	Д.Дарамренчин, Д.Нандинсүвд
4	2668	Адууны амталж хатаасан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга	2016-11-30	Б.Эркигүл
5	2669	Араан дамжуулгат дотоод шаталтат хөдөлгүүр	2016-11-30	Ш.Баяртулга
6	2670	Тайвшруулах улавч бэлтгэх, хэрэглэх арга	2016-12-14	Одьтан ХХК
7	2671	Гахайн хуйхнаас утаслаг уургийн баяжуулагч үйлдвэрлэх арга	2016-12-22	Н.Чимэгээ, Т.Болормаа, А.Баянзул, Л.Дамдинсүрэн
8	2672	Модны мөчирт хор цацагч	2016-12-27	Б.Цэрэнчимэд
9	2673	Нүхэн жорлонгийн угсардаг бүхээг	2017-01-18	Ц.Насанбат, Н.Батхүү
10	2674	Целлюлоза энзимээр сүрлийг боловсруулж малын нэмэгдэл тэжээлд ашиглах	2017-01-19	А.Отгонжаргал, Ч.Уранхайч, Н.Тогтохбаяр
11	2675	Ксилаза энзимээр сүрлийг боловсруулж малын нэмэгдэл тэжээлд ашиглах	2017-01-19	А.Отгонжаргал, Ч.Уранхайч, Н.Тогтохбаяр
12	2676	Элс бодис цацагчийн хийн тормозны системгүй автомашинд зориулсан нэмэлт хийц, түүний угсралт	2017-01-24	Алтайнсолонго сүтэй ХХК
13	2677	Спираль хоолойтой нарны коллектор	2017-01-31	Д.Баатархүү, LEE HEE KYU, Ж.Амгаланзул
14	2678	Ус төрөгчийн генератор	2017-01-31	И.Бодий, П.Баатарсүрэн
15	2679	Төмс ялгах зөөврийн төхөөрөмж	2017-02-02	Верса-Өрөм ХХК
16	2680	Бог малын зөөврийн хашаа түүний бүтэц, угсрах, ашиглах арга	2017-02-02	Верса-Өрөм ХХК
17	2681	Бог малын угаалга, эмчилгээ, үйлчилгээний зөөврийн бага оврын төхөөрөмж	2017-02-03	Верса-Өрөм ХХК
18	2682	Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлаар шахмал түлш үйлдвэрлэх арга	2017-02-10	Ж.Батбилэг
19	2683	Эрчлэх төхөөрөмж	2017-02-10	Ч.Хастунгалаг, Б.Нямгэрэл, Д.Түвшинжаргал
20	2684	Шонхор (Falco) шувууны тоо, нөөцийг бодитоор тогтоох арга	2017-02-17	Г.Амарсанаа, Ц.Одбаяр



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/320

Улаанбаатар хот

Техникийн тодорхойлолт, загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэлийн лавлагааны үнэт цаасны техникийн тодорхойлолт, загварыг нэгдүгээр хавсралтаар, Төрийн үйлчилгээний цахим машины лавлагааны үнэт цаасны техникийн тодорхойлолт, загварыг хоёрдугаар хавсралтаар, Бичвэргүй ИУБ маягтын техникийн тодорхойлолт, загварыг гуравдугаар хавсралтаар, "ИУБ 31" маягтын техникийн тодорхойлолт, загварыг дөрөвдүгээр хавсралтаар, "ИУБ 21" маягтын техникийн тодорхойлолт, загварыг тавдугаар хавсралтаар, "ИУБ 3" маягтын техникийн тодорхойлолт, загварыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга /Б.Бадамцэцэгт/-д даалгасугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар

А/321

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2205060449 дугаарыг т  
хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Агро Стейт" /6123953/ ХХК нь өөрийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-2205060449 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Үйлдвэрийн төвийн бүс /16020/ гудамж, 20/1 тоот хувийн сууц, гаражийн зориулалттай барилгыг нурааж буулгасан тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2205060449 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205060449 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000526833 дугаартай гэрчилгээг тус бүр хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205060449 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Л.Оюунчимэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ц.Билэгсүх нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар

А/322

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2201015371,  
Г-2201026965, Г-2201014865 дугаарыг  
хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн О.Мишээл /ТА89052611/ нь өөрийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-2201015371 дугаарт бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны Зүүн баян уул 30 дугаар гудамжны 11 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар өмчлөх эрхээсээ татгалзсан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2201015371 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

1.1. Иргэн О.Мишээл /ТА89052611/ нь өөрийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-2201014865 дугаарт бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны Зүүн баян уул 30 дугаар гудамжны 11а тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар өмчлөх эрхээсээ татгалзсан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2201014865 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

1.2. Иргэн О.Мишээл /ТА89052611/ нь өөрийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-2201026965 дугаарт бүртгэлтэй Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны Зүүн баян уул 30 дугаар гудамжны 11б тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар өмчлөх эрхээсээ татгалзсан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2201026965 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2201015371, Г-2201014865, Г-2201026965 дугааруудыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай

Бүртгэлийн  
Хүчингүй  
Болгож  
Хувиар  
Хувиар  
Хувиар

холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000463882, 0004463838, 000463839 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2201015371, Г-2201014865, Г-2201026965 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд бичилт хийж хаахыг Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Н.Бадрахцогт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Г.Цолмон нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/323

Улаанбаатар хот

Бүртгэл хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, хяналтын улсын байцаагчийн 2017 оны 637 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Лэлметалл" ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг 2016 оны 7 дугаар сарын 7-ны өдөр улсын бүртгэлд бүртгэхэд үндэслэсэн Нийслэлийн Баянзүрх дүүргийн тойргийн 279 дугаартай нотариатчийн гэрчилсэн гэх 2016 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 715 дугаартай "Компанийн эрх шилжүүлэх гэрээ", 716 дугаартай "Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ" хуурамч болох нь тус газрын Хяналтын газрын хяналт шалгалтаар тогтоогдож байх тул "Лэлметалл" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Батмөнхийг өөрчлөн Т.Сандагдоржийг бүртгэсэн, компанийн гүйцэтгэх захирал Б.Батмөнхийг өөрчлөн Т.Сандагдоржийг бүртгэсэн, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн дахин олгосон бүртгэлийг тус тус хүчингүй болгосугай.

2."Лэлметалл" ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг тус газрын улсын бүртгэлд 2016 оны 7 дугаар сарын 7-ны өдөр бүртгүүлсэн бүртгэлийг хүчингүй болгосонтой холбогдуулан улсын бүртгэлийн 000070803 дугаартай гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Д.Болормаа, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэг нарт даалгасугай.

ДАРГА, УЛСЫН  
ЕРӨНХИЙ БҮРТГЭГЧ

Р.СОДХҮҮ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ**

14171 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Цагдаагийн гудамж, Утас: 351245, Факс: (976-11) 351245  
<http://www.burtgel.gov.mn>

2017.03.30 № 63Э

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
БҮРТГЭЛИЙН ГАЗАРТ

Бүртгэл хянасан тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, Улсын бүртгэлийн хяналтын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, Оюуны өмч, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Иргэн Б.Батмөнхөөс тус газарт хандан "Танай байгууллагын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын ажилтан Б.Амартүвшин иргэн миний 100% хувьцааг нь эзэмшдэг Лэлметал ХХК-ийн хувьцааг иргэн Т.Сандагдорж гэгчид хууль бусаар, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг илтэд зөрчин 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шилжүүлэн бүртгэл хийсэн байна. Хууль бусаар шилжүүлснийг дараах байдлаар тодорхойлж байна:

1. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч өөрчлөх болон хувьцаа эзэмшигчийн хувь өөрчлөхөд шаардагдах материалаас үзэхэд:

А/Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь хууль ёсны өмчлөгч надад байсаар атал эх хувийг шаардаж авалгүйгээр, илт хууль бусаар шилжүүлсэн байна

Б/Татвар санхүүгийн байгууллагын баталгаажуулсан тайлан балансыг 2016 оны бус 2015 оны 3 дугаар улирлын баталгаажуулаагүй тайлангаар бүрдүүлсэн

В/Эрх хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдэд урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах, нотлох ёстой байтал иргэн Б.Батмөнх надад ямар нэгэн хэлбэрээр мэдэгдэлгүйгээр бусдад дур мэдэн шилжүүлсэн байна.

Г/Өргөдөл гаргах эрхгүй этгээд хуурамч баримт бичиг үйлдэж, өөрөө хүсэлт гарган бусдын хөрөнгийг өөрийн нэр дээр шилжүүлэн авч байгаа илт хууль бус үйлдлийг мэдсээр атлаа бүртгэл хийсэн.

2. Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ дахин авахад шаардлагатай материалаас:

А/Хувьцаа эзэмшигчийн шийдвэр тогтоол, хурлын тэмдэглэлгүй

Б/Өдөр тутмын сонинд зарлуулсан сонингийн эх хувь байхгүй. Учир нь зарыг 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр өгч, 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн Шуурхай зар сонинд хэвлэгдсэн.

В/Өргөдөл гаргах эрх бүхий этгээд нь төлөөлөх эрхгүй, итгэмжлэлгүй байсан байна.

Дээрх бүх шаардлагуудыг үл хэрэгсэн 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдөр компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин гаргуулж, миний хууль ёсны бүх хувьцааг иргэн Т.Сандагдоржид шилжүүлсэн байна.

Иймд Та Улсын бүртгэлийн ерөнхий хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд улсын бүртгэгч Б.Амартүвшингийн шийдвэрийг хүчингүй болгож, хууль ёсны эзэмшигч миний нэр дээр шилжүүлж өгнө үү" гэх хүсэлтийн дагуу хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.1."Лэлметалл" ХХК нь анх 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр улсын бүртгэлийн 9011385116 дугаарт, хуулийн этгээдийн 5668328 регистртэйгээр бүртгэгдсэн байх бөгөөд компанийн 100%-ийн хувьцаа эзэмшигчээр иргэн Т.Сандагдорж /ХИ84022738/ бүртгэгдэж байсан байна.

1.2."Лэлметалл" ХХК-ийн 100%-ийн хувьцааг 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Хувьцаа худалдах, авах гэрээ, компанийн эрх шилжүүлэх гэрээ зэргийг үндэслэн компанийн 100%-ийн хувьцаа эзэмшигчээр иргэн Б.Бат-Эрдэнэ /ИЭ69013011/ бүртгэгдсэн байна

1.3."Лэлметалл" ХХК-ийн 100%-ийн хувьцааг 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр компанийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, компанийн эрх шилжүүлэх гэрээ зэргийг үндэслэн компанийн 100%-ийн хувьцаа эзэмшигчээр иргэн Б.Батмөнх /ИЭ67033110/ бүртгэгдсэн байна.

1.4."Лэлметалл" ХХК-ийн 100%-ийн хувьцааг 2016 оны 07 дугаар сарын 4-ний өдрийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн тойргийн нотариатч /279 хувийн дугаартай/-ийн гэрчилсэн компанийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээг үндэслэн компанийн 100%-ийн хувьцаа эзэмшигчээр иргэн Т.Сандагдорж /ХИ84022738/ бүртгэгдэж, улсын бүртгэлийн 000070803 дугаартай гэрчилгээг шинээр олгож, Т.Сандагдоржийг гүйцэтгэх захирлаар томилсныг тус тус улсын бүртгэлд улсын бүртгэгч Б.Амартүвшин 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүртгэсэн байх бөгөөд ийнхүү улсын бүртгэлд бүртгэхдээ дараах баримт бичгийг үндэслэсэн байна.Үүнд:

1.4.1.УБ-05 маягт

1.4.2."Лэлметалл" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр /энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт компанийн 100%-ийн хувьцааг Т.Сандагдоржид шилжүүлэх, 2 дахь хэсэгт компанийг дүрмийг батлах, 3 дахь заалтад зохих материалыг бүрдүүлэн УБСЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэх талаар заасан байна/.

1.4.3."Лэлметалл" ХХК-ийн шинэчилсэн дүрэм

1.4.4.Нийслэлийн Баянзүрх дүүргийн тойргийн нотариатчийн гэрчилсэн компанийн эрх шилжүүлэх гэрээ /гэрээний дугаар 715/

1.4.4.Нийслэлийн Баянзүрх дүүргийн тойргийн нотариатчийн гэрчилсэн компанийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээ /гэрээний дугаар 716/;

1.4.5. Шуурхай зар сонинд 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр зар өгсөн талаарх баримт.

2. "Лэлметалл" ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүртгэхэд үндэслэсэн нотариатчийн хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, компанийн эрх шилжүүлэх гэрээ зэрэг нь хуурамч болох нь дараах байдлаар тогтоогдож байна:

2.1. "Лэлметалл" ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшигч Б.Батмөнхийн тус газарт хандан гаргасан хүсэлтийн 1-ийн "Д" хэсэгт өргөдөл гаргах эрхгүй этгээд хуурамч бичиг баримт үйлдэж . . . бүртгэл хийлгэсэн.

2.2. Нийслэлийн Баянзүрх дүүргийн тойргийн нотариатч /хувийн дугаар 279/ Л.Халиун тус газарт гаргасан тайлбартаа "Миний бие Лхасүрэн овогтой Халиун нь Баянзүрх дүүргийн тойргийн 279 дугаартай нотариатч билээ.

Гэтэл 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдөр компанийн эрх шилжүүлэх гэрээг хийсэн талаар иргэн Б.Батмөнхийн гомдлоор Баянгол дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс, мөн тус газрын хэлснээр намайг хийсэн эсэх талаар надаас тодруулга авахад нь би уг гэрээг хийгээгүй гэдгийг хэлж, нотлох баримтаа өгсөн болно.

Уг хийсэн гэрээг би хийгээгүй, мөн тамга тэмдгийг хуурамчаар хийсэн ба баталгааны тэмдэг дээрх миний гарын үсэг нь миний гарын үсэг биш байна.

Мөн тухайн өдөр буюу 2016 оны 07 дугаар сарын 04-нд 715, 716 дугаартай гэрээ хийгдээгүй болно" гэжээ.

Баянзүрх дүүргийн нотариатч /279 хувийн дугаартай/ Л.Халиуны гэрээний бүртгэлийн дэвтэрт үзлэг хийхэд 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдөр 2914-2926 дугаартай гэрээнүүд бүртгэгдсэн байна.

2.3. Хүсэлт гаргагч Б.Батмөнхийн тус газарт гаргасан хүсэлтэд хавсарган өгсөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээчийн 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 1301 дугаартай дүгнэлтийн дүгнэх хэсгийн 2-т ОӨУБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт хадгалагдаж буй "Лэлметалл" ХХК-ийн 2016 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн "Компанийн эрх шилжүүлэх гэрээ"-ний доод хэсэг, "Гэрээг үйлдсэн" гэсний дээр байх тамганы дардас нь шинжилгээнд харьцуулах загвараар ирүүлсэн 279 дугаартай нотариатчийн тамганы дардасны загваруудтай тохирохгүй байна" гэсэн байна.

2.4. "Лэлметалл" ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг тус газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүртгэсэн бүртгэлээр компанийн гүйцэтгэх захирал Б.Батмөнхийг өөрчлөн Т.Сандагдоржийг гүйцэтгэх захирлаар бүртгэсэн байх бөгөөд энэ талаарх эрх бүхий этгээдийн шийдвэр, нотлох баримт хувийн хэрэгт авагдаагүй байна.

2.5. "Лэлметалл" ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг тус газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдөр бүртгэсэн бүртгэлээр компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр дахин олгосон байх

бөгөөд өмнөх улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон эрх бүхий этгээдийн шийдвэр хувийн хэрэгт авагдаагүй байна.

2.6.Улсын бүртгэгч Б.Амартүвшин тус газарт гаргасан тайлбартаа "Лэлметалл ХХК-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчээс Б.Батмөнхийг хасч Т.Сандагдоржийг нэмсэн бүртгэлд Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журмын 4.2-т заасны дагуу баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл, үүсгэн байгуулагч болон эрх барих дээд байгууллагын шийдвэр, нотариатаар гэрчлүүлсэн холбогдох гэрээ, улсын тэмдэгтийн хураамж тус бүр бүрдүүлсэн байсан.

Тухайн үед тамга, тэмдэг хариуцсан бүртгэлийн цонхонд иргэдэд үйлчилгээ үзүүлж байхад ажлын ачаалал их шалтгаанаар давхар нэмэлт өөрчлөлтийн нийт 7 бүртгэл хуваарилагдаж бүртгэл хийсэн.

Иргэдэд үйлчилгээ үзүүлэхийн хажуугаар үйлчилгээний цонхонд сууж давхар бүртгэл хийх нь алдаа зөрчил гаргах нөхцлийг бүрдүүлж байна" гэжээ.

3."Лэлметалл" ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт /Компанийн 100%-ийн хувьцаа эзэмшигч Б.Батмөнхийг өөрчилж Т.Сандагдоржийг бүртгэсэн, компанийн гүйцэтгэх захирлаар Т.Сандагдоржийг бүртгэсэн, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр дахин олгосон/-ийг улсын бүртгэлд 2016 оны 07 дугаар сарын0 7-ны өдөр бүртгэсэн бүртгэлд дараах хууль тогтоомжууд зөрчигдсөн байна.Үүнд:

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3.1.5-д "нотлох баримтад үндэслэж, хуульд заасан журмын дагуу хөтлөх", 17.3-т "Улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа этгээд нь бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй . . .", Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5.2-д "Энэ хуулийн 5.3-5.5-д заасан улсын бүртгэл хийлгэх тухай хүсэлт, түүнд хавсаргасан нотлох баримт бичгийг авч хянан улсын бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргах", 11.5.3-т "энэ хуулийн 11.5.2-т заасан нотлох баримт нь зөрчилтэй, бүрэн бус, холбогдох хуулийн заалтыг зөрчсөн бол улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах", 11.5.12-т өөрийн гүйцэтгэсэн улсын бүртгэлийн хувийн хэргийн нотлох баримтын бүрдэл болон түүний үнэн зөвийг хуулийн өмнө хариуцах" гэж заасныг тус тус зөрчсөн нь хувийн хэрэгт авагдсан нотлох баримт, иргэн Б.Батмөнхийн тус газарт гаргасан хүсэлт, түүнд хавсарган өгсөн нотлох баримт бичгүүд, нотариатч Л.Халиун нарын тайлбар зэргээр тус тус тогтоогдож байх тул ДҮГНЭХ нь:

3.1.Улсын бүртгэлийн 9011385116 дугаарт бүртгэлтэй, хуулийн этгээдийн 5668328 регистртэй, "Лэлметалл" ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт /компанийн хувьцаа эзэмшигчийг өөрчилсөн, гүйцэтгэх удирдлагыг өөрчилсөн, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр олгосон/-ийг 2016 оны 07 дугаар сарын 0 7-ны өдөр тус газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн бүртгэлийг ОӨУБЕГ-ын дарга бөгөөд Улсын ерөнхий бүртгэгчийн шийдвэрээр хүчингүй болгох;

3.2.Улсын бүртгэлийн болон холбогдох хууль тогтоомжийг зөрчиж бүртгэл хийсэн Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч Б.Амартүвшинд Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах эсэх талаарх саналыг

Төрийн албаны зөвлөлийн ОӨУБЕГ дахь салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ч.ЭРДЭНЭЧИМЭГ

ХЯНАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ



Б.ГАНЗОРИГ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар

A/324

Улаанбаатар хот

Хуралд оролцуулах тухай


Монгол Улсын "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас ирүүлсэн урилгад тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага, Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газартай хамтран 2017 оны 4 дүгээр сарын 3-наас 5-ны өдрүүдэд Сингапур Улсад "Хамтын удирдлагын байгууллагын сайн засаглал" сэдэвт семинар, "Марракешийн гэрээ болон Бээжингийн гэрээг дэмжих нь" сэдэвт Ази, Номхон далайн бүсийн хуралдаанд тус газрын Зохиогчийн эрхийн газрын дарга Эрдэнэбаярын Мягмардоржийг зохион байгуулагч талын санхүүжилтээр оролцуулсугай.

2. Тус хуралд идэвхтэй оролцож, үр дүнгийн талаар Даргын зөвлөлд мэдээлэл хийхийг Э.Мягмардоржид үүрэг болгосугай.

ДАРГА

Я.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/агс

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Б.Хандхүүгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ганбатын Мөнхсарнайг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Мөнхсарнайд тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Т.Булгантамирт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 03 өдөр

Дугаар

А/226

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2206045916  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ш.Баянтунгалаг /НЮ73111828/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206045916 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, Буянт ухаа Наадамчдын зам гудамж, 710 дугаар байрны С-130 тоот автозогсоол нь "Эд хөрөнгийн доголдол арилгуулж, өмчлөл баталгаажуулах гэрээ"-ний хүрээнд нураагдсан тул эрхийн улсын бүртгэлийн Y-2206045916 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Дугаар бүхий эрхийн улсын бүртгэлийг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000485448 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Хувийн хэрэг бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/327

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 5.11, 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1. Иргэн Г.Энхтөр /ЧП84061517/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2203025117 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Эрхүүгийн гудамж, 29 дүгээр байрны 17 тоот орон сууцны 000193435 дугаартай;

1.2. Иргэн Р.Ганбат /УХ46012210/, Д.Лхамжав /ХА46070181/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2203011814 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, 31 дүгээр байрны 51 тоот орон сууцны 0105330 дугаартай;

1.3. Иргэн Э.Энхчимэг /ХЖ86121409/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204026213 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 15 дугаар хороолол /13343/, Энхтайваны өргөн чөлөө, 62 тоот хаягт байрлах, үйлчилгээ, оффисын зориулалттай эд хөрөнгийн 000075655 дугаартай;

1.4. Иргэн Б.Цагаанцоож /ПЮ78111618/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204006270 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Чулуутын 5 дугаар гудамж, 118 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000378512 дугаартай;

1.5. Иргэн С.Нарантуяа /ЧН59092604/, А.Мөнхсарнай /УО05322401/, Ц.Нямдулам /УИ91101366/, Ц.Батбаяр /ЧН83011313/, Ц.Энхчимэг /ЧН81061401/, Ц.Энхмаа /ЧН85061424/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2205014996 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 12 дугаар хороо, 6 дугаар бичил хороолол, 26 дугаар байрны 9 тоот орон сууцны 000471275 дугаартай;

1.6. Иргэн Б.Дашзэвэг /ЦБ46021015/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2207001185 дугаарт бүртгэлтэй, Налайх дүүргийн 2 дугаар хороо, 55 дугаар 23 тоот орон сууцны 000419340 дугаартай.

2. Шүүхийн шийдвэрийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

2.1. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 413 дугаар шүүгчийн шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 221/МА2016/0532 дугаар магадлал, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2016 оны 335 дугаар тогтоол, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 0173 дугаар гүйцэтгэх хуудас, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10282 дугаар шүүгчийн захирамж, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 1/13337 дугаар албан бичиг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 1/5080 тоот албан бичиг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 1/6696 тоот албан бичгийг тус тус үндэслэн "Монтрак групп" ХХК /5520169/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204046688 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо /13332/, Нарны зам, 70 тоот хаягт байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай эд хөрөнгийн 000234824 дугаартай;

2.2. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 413 дугаар шүүгчийн шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 221/МА2016/0532 дугаар магадлал, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2016 оны 335 дугаар тогтоол, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 0173 дугаар гүйцэтгэх хуудас, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10282 дугаар шүүгчийн захирамж, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 1/13337 дугаар албан бичиг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 1/5080 тоот албан бичиг, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 1/6696 тоот албан бичгийг тус тус үндэслэн "Монтрак групп" ХХК /5520169/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2204046689 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо /13332/, Нарны зам, 70/1 тоот хаягт байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай эд хөрөнгийн 000234825 дугаартай.

3. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 03 өдөр

Дугаар

А/ЗЭВ

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 5.11, 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1. Иргэн М.Сүнжидмаа /ДА88062003/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2201038090 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороо, Орбит 56 дугаар гудамж, 28/А тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000408378 дугаартай;

1.2. Иргэн Ц.Баярсайхан /ЗЮ83032411/-ы өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2201023084 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороо, Найрамдлын зам /18222/, 6 дугаар байрны 2 тоот орон сууцны 100020 дугаартай;

1.3. Иргэн С.Ганболд /УЕ69061852/, Г.Алтанзул /УШ95010303/, Г.Энхцэцэг /УШ93052200/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2201014096 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хороо, Одонт 21 дүгээр гудамж, 11 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000059078 дугаартай;

1.4. Иргэн С.Ганболд /УЕ69061852/, Г.Алтанзул /УШ95010303/, Г.Энхцэцэг /УШ93052200/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2201025448 дугаарт бүртгэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хороо, Одонт 21 дүгээр гудамж, 11 тоот хувийн сууцны 000132286 дугаартай;

1.5. Иргэн Д.Ариунаа /СЖ68021923/, З.Ичинхорлоо /СЖ94031901/, З.Одонхүү /СЖ96021316/, Б.Зоригт /СЖ66012811/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2202005191 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Сурагчийн 12 дугаар гудамж, 90 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 15028 дугаартай;

1.6. Иргэн Д.Ариунаа /СЖ68021923/, З.Ичинхорлоо /СЖ94031901/, З.Одонхүү /СЖ96021316/, Б.Зоригт /СЖ66012811/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202012178 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Сурагчийн 12 дугаар гудамж, 90 тоот хувийн сууцны 14560 дугаартай;

1.7. Иргэн О.Батнасан /ДЛ93121810/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2205062928 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Дунд гол гудамж, 30/Б дүгээр байрны 27 тоот орон сууцны 487614 дугаартай;

1.8.Иргэн Б.Ариунжаргал /ШБ85110463/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2205056486 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 8 дугаар хороо, 3 дугаар хороолол, 45/А дугаар байрны 156 тоот орон сууцны 000579946 дугаартай.

2. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 102/ШШ2016/02939 дугаар шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 1224 дүгээр магадлал, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2016 оны 001/ХТ2016/01143 дугаар тогтоол, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 102/ШЗ2017/01374 дүгээр шүүгчийн захирамж, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 1/6010 тоот албан бичгийг тус тус үндэслэн иргэн Ү.Байгалмаа /ЧЛ64011608/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2205005209 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 14 дүгээр хороо, 3 дугаар хороолол, Ард Аюушийн өргөн чөлөө, 1/8 хаягт байрлах, үйлчилгээний зориулалттай эд хөрөнгийн 000212575 дугаартай.

3. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар

№/329

Улаанбаатар хот

Патент эзэмшигчийн эрх  
шилжүүлэх тухай

Патентийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т заасныг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн хүсэлтийг хянан үзээд эрх шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн нэрийг хавсралтаар баталсугай.
3. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулж, эзэмшигчдэд Патент олгосугай.

ДАРГА

Р. СОДХҮҮ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын  
даргын *Б.О.О* дугаар тушаалын хавсралт

**Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патентийн жагсаалт**



No.	Улсын бүртгэлийн дугаар	Эзэмшигчийн бүртгэгдсэн нэр, хаяг	Эзэмшичийн өөрчлөгдсөн нэр, хаяг
1	3803	CRYSTAL LAGOONS CORPORATION LLC	CRYSTAL LAGOONS (CURACAO) B.V.
2	2102	Н.Чагнаа, 3.Бүдханд	Монсилвер ХХК
3	4305	Н.Чагнаа	Монсилвер ХХК
4	3699	SynCoal Solutions Inc	Specialty Applications of Wyoming, LLC
5	2346	Уртнасан овогтой Баатаржав	Баатаржав овогтой Индира



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар #/230

Улаанбаатар хот

Барааны тэмдэг эзэмшигчийн нэр,  
хаягийг өөрчлөх тухай

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Барааны тэмдэг эзэмшигчдийн хүсэлтийг хянан үзээд нэр, хаяг өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
2. Барааны тэмдэг эзэмшигчдийн нэр, хаягийн өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.
3. Барааны тэмдгийн бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулж, эзэмшигчдэд Гэрчилгээ олгосугай.

ДАРГА

Р. СОДХҮҮ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын  
даргын /14.30 дугаар тушаалын хавсралт

**Барааны тэмдэг эзэмшигчийн эрх шилжүүлэх,  
нэр, хаягийг өөрчлөх, жагсаалт**

No.	Улсын бүртгэлийн дугаар	Эзэмшигчийн нэр, хаяг	бүртгэгдсэн	Эзэмшигчийн өөрчлөгдсөн нэр, хаяг
1	7497	Miller Brewing International, Inc		Coors Brewing Company
2	8151	Miller Brewing International, Inc		Coors Brewing Company
3	662	EFFEM FOODS PTY LTD		Mars, Incorporated
4	4231	KABUSHIKI KAISHA SONY COMPUTER ENTERTAINMENT		Sony Interactive Entertainment Inc.
5	4719	KABUSHIKI KAISHA SONY COMPUTER ENTERTAINMENT		Sony Interactive Entertainment Inc.
6	6334	226, shinmunro jongno-gu, seoul korea (south)		25, Yulgok-ro 2-gil, Jongno-gu, Seoul, Republic of Korea
7	7503	GlaxoSmithKline LLC		Block Drug Company, Inc.
8	7502	GlaxoSmithKline LLC		Block Drug Company, Inc.
9	6573	Novartis AG		Novartis Consumer Health S.A.
10	7600	Glaxo Group Limited		GlaxoSmithKline Consumer Healthcare (UK) IP Limited
11	11232	Glaxo Group Limited		GlaxoSmithKline Consumer Healthcare (UK) IP Limited
12	7508	Glaxo Group Limited		GlaxoSmithKline Consumer Healthcare (UK) IP Limited
13	7599	Glaxo Group Limited		GlaxoSmithKline Consumer Healthcare (UK) IP Limited
14	7394	Glaxo Group Limited		GlaxoSmithKline Consumer Healthcare (UK) IP Limited
15	3414	SOUTHERN PROPERTIES, INC	COMFORT	Sazerac Brands, LLC
16	2417	SOUTHERN PROPERTIES, INC	COMFORT	Sazerac Brands, LLC
17	2418	SOUTHERN PROPERTIES, INC	COMFORT	Sazerac Brands, LLC
18	328	KABUSHIKI KAISHA SEISAKUSHO	HITACHI	Hitachi limited
19	327	KABUSHIKI KAISHA SEISAKUSHO	HITACHI	Hitachi limited
20	6077	С.Ууганзаяа		Д.Энхбаатар
21	14550	THE GILLETTE COMPANY		THE GILLETTE COMPANY LLC
22	1077	THE GILLETTE COMPANY		THE GILLETTE COMPANY LLC

23.	1078	THE GILLETTE COMPANY	THE GILLETTE COMPANY LLC
24.	1079	THE GILLETTE COMPANY	THE GILLETTE COMPANY LLC
25.	5115	THE GILLETTE COMPANY	THE GILLETTE COMPANY LLC
26.	6001	Б.Ариунболд	Б.Аpro
27.	9790	International House, Castle Hill Victoria Road, Douglas Isle of Man, British Isles IM2 4RB; GB	First Names House, Victoria Road, Douglas, Isle of Man, IM2 4DF, British Isles
28.	9696	International House, Castle Hill Victoria Road, Douglas Isle of Man, British Isles IM2 4RB; GB	First Names House, Victoria Road, Douglas, Isle of Man, IM2 4DF, British Isles
29.	9697	International House, Castle Hill Victoria Road, Douglas Isle of Man, British Isles IM2 4RB; GB	First Names House, Victoria Road, Douglas, Isle of Man, IM2 4DF, British Isles
30.	7357	International House, Castle Hill Victoria Road, Douglas Isle of Man, British Isles IM2 4RB; GB	First Names House, Victoria Road, Douglas, Isle of Man, IM2 4DF, British Isles
31.	7359	International House, Castle Hill Victoria Road, Douglas Isle of Man, British Isles IM2 4RB; GB	First Names House, Victoria Road, Douglas, Isle of Man, IM2 4DF, British Isles
32.	3782	4-1, Nishi-shinjuku 2-chome, Shinjuku-ku, Tokyo, Japan	1-6, Shinjuku 4-chome, Shinjuku-ku, Tokyo, Japan
33.	2120	4-1, Nishi-shinjuku 2-chome, Shinjuku-ku, Tokyo, Japan	1-6, Shinjuku 4-chome, Shinjuku-ku, Tokyo, Japan
34.	4479	4-1, Nishi-shinjuku 2-chome, Shinjuku-ku, Tokyo, Japan	1-6, Shinjuku 4-chome, Shinjuku-ku, Tokyo, Japan
35.	6542	1111 Westchester Avenue, White Plains, New York 10604, USA	Starwood Hotels & Resorts Worldwide LLC, 10400 Fernwood Road, Department 955.23, Bethesda, Maryland 20817, USA
36.	6543	1111 Westchester Avenue, White Plains, New York 10604, USA	Starwood Hotels & Resorts Worldwide LLC, 10400 Fernwood Road, Department 955.23, Bethesda, Maryland 20817, USA
37.	6544	1111 Westchester Avenue, White Plains, New York 10604, USA	Starwood Hotels & Resorts Worldwide LLC, 10400 Fernwood Road, Department 955.23, Bethesda, Maryland 20817, USA
38.	6545	1111 Westchester Avenue, White Plains, New York 10604, USA	Starwood Hotels & Resorts Worldwide LLC, 10400 Fernwood Road, Department 955.23, Bethesda, Maryland 20817, USA
39.	1958	MERIAL LIMITED	MERIAL, INC.
40.	4259	MERIAL LIMITED	MERIAL, INC.
41.	2727	2 Burmah Castrol House Pipers Way Swindon Wiltshire SN3 1RE	Technology Centre, Whitchurch Hill, Pangbourne,

		England	Reading R G8 7QR, United Kingdom
42.	6635	С.Энхцогт	Витафит групп ХХК
43.	6231	771 Corporate Drive, Suite-505, Lexington, Kentucky 40503	1400 Centrepark Blvd., Suite 200, West Palm Beach, FL 33401, USA
44.	6341	UNITED STATES POLO ASSOCIATION	UNITED STATES POLO ASSOCIATION
45.	1938	Viacom 1 International Inc.	Viacom International Inc.
46.	1939	Viacom 1 International Inc.	Viacom International Inc.
47.	1934	Haier Group, Corporation	Haier Group Corporation
48.	1935	Haier Group, Corporation	Haier Group Corporation
49.	6465	Chongqing Changan Automobile LLC	Chongqing Changan Automobile Co., Ltd.
50.	6427	GALLAHER CO., LTD	GALLAHER LIMITED
51.	6457	GALLAHER CO., LTD	GALLAHER LIMITED
52.	6552	Pacific inter-Link 620, Sbn.Bhd	Pacific inter-Link Sbn.Bhd
53.	2200	Ulica Ante Starčevića 32, HR-48000 Koprivnica, CROATIA	Ulica Ante Starčevića 32, HR-48000 Koprivnica, CROATIA
54.	14373	Моор-Эксланд ХХК	Моор-Эксланд ХХК
55.	6240	Д. Лхагвасүрэн	Д. Лхасүрэн
56.	12880	А.Номин-Эрдэнэ	"Монгол Интернэйшнл" ХХК Брэнд



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 1/331

Улаанбаатар хот

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг  
бүртгэж, патент олгох тухай

Монгол Улсын Патентийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Патент олгох шалгуур хангасан 13 шинэ бүтээлийн патент эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, патент олгох шалгуур хангасан 17 бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг улсын бүртгэлд бүртгэсүгэй.
2. Тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан шинэ бүтээлийн патент эзэмшигч, хоёрдугаар хавсралтад дурдсан бүтээгдэхүүний загварын патент эзэмшигч нарт патент олгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2017 оны 1831 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Шинэ бүтээлийн патентийн жагсаалт

№	Патентийн дугаар	Шинэ бүтээлийн нэр	Анхдагч огноо	Патент эзэмшигч
1.	4503	Овьёосны бэлэн хоол үйлдвэрлэх арга	2015-05-15	Ш.Сувд
2.	4504	Олон ургамлын цай, түүнийг бэлтгэх арга	2015-05-15	Ш.Сувд
3.	4505	Цайны хийц, түүнийг үйлдвэрлэх арга	2015-05-15	Ш.Сувд
4.	4506	Нүүрсний гаралтай конденсацлагддаг шингэний ялгаралтыг сайжруулах нүүрс боловсруулах процесс	2015-07-07	C2O TECHNOLOGIES, LLC
5.	4507	Сүүтэй цай, түүнийг үйлдвэрлэх арга	2015-09-28	Дэлгэрмөнгөн далай ХХК
6.	4508	Нүүрс ба минералийн шингэн зуурмаг хатаах арга ба систем	2015-10-13	VITRINITE SERVICES, LLC
7.	4509	Цеолит агуулсан төл малын нэмэлт тэжээл бэлтгэх болон хэрэглэх арга	2015-10-26	М.Золзаяа, Ш.Дэмбэрэл
8.	4510	Малын шимэгчийн эсрэг үйлдэлтэй дусаалга, түүнийг бэлтгэх арга	2015-11-02	Мал Эмнэлэгийн Хүрээлэн
9.	4511	Малын шимэгчийн эсрэг үйлдэлтэй дусаалга, түүнийг бэлтгэх арга	2015-11-02	Мал Эмнэлэгийн Хүрээлэн
10.	4512	Мергель ашиглан портландцементийн клинкер гарган авах арга	2015-11-17	Монгол Улсын Их Сургууль
11.	4513	Уусгагчаар хандлан тунгаагч төхөөрөмж	2015-12-18	OUTOTEC (FINLAND) OY
12.	4514	Үрэвсэл намдаах хандмал эм бэлтгэх арга, түүний найрлага	2015-12-24	Монос Эм Судлалын Хүрээлэн
13.	4515	Хүхэр багатай төмрийн хүдэр үйлдвэрлэх арга	2015-12-25	KABUSHIKI KAISHA KOBE SEIKO SHO (KOBE STEEL, LTD.)

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2017 оны 12 сар 1 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Бүтээгдэхүүний загварын патентийн жагсаалт**

№	Патентийн дугаар	Бүтээгдэхүүний загварын нэр	Анхдагч огноо	Патент эзэмшигч
1.	2596	www.gogo.mn сайтын вэб дизайн	2015-10-23	Монгол Контент ХХК
2.	2597	Narural patch сав баглаа боодол	2015-11-03	Нано Супер Патч ХХК
3.	2598	THE WORLD KHAN лонх	2015-11-25	Б.Мөнхбат
4.	2599	"Алаг шоо", "Хөлөгт тоглоом", "Ээрүүл тоглоом", "Дүрс бүтээх тоглоом", "Дааганы уралдаан тоглоом", "Хургачин хүү тоглоом"	2015-11-27	Д.Баянмөнх, Ж.Дэмбэрэл
5.	2600	Буян арвижуулах Бэ гам	2016-01-07	П.Мэндбаяр
6.	2601	Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол /Бани, Бэни/	2016-01-07	СҮҮ ХК
7.	2602	Шивүүрийн зүүний аргаар хийсэн Эсгий 5 хошуу мал (Сарлаг)	2016-01-07	Н.Наранцэцэг
8.	2603	Тарагны сав баглаа боодол "Элгэн тараг"	2016-01-20	СҮҮ ХК
9.	2604	Зүү ороох оёдол, битүү хатгамал оёдлоор оёсон гар утасны гэр	2016-01-21	Д.Дуламсүрэн
10.	2605	Ахуйн шингэрүүлсэн хийн түлшний шошго	2016-02-05	Эрдэм Газ ХХК
11.	2606	Гурван хөлт тулга №1	2016-02-17	Ц.Махбал
12.	2607	Тансаг ааруул кофетэй, Тансаг ааруул шоколадтай, Тансаг ааруул гангатай	2016-02-26	Г.Гэрэлсайхан
13.	2608	UB ECO car	2016-03-11	Д.Эрдэмбилэг
14.	2609	Онгоц /airlpane/	2016-03-28	ASIANA AIRLINES, INC
15.	2610	Гурван Эрхэм	2016-04-04	А.Ганзориг
16.	2611	/Leather dealer/ арьсан бүтээгдэхүүн	2016-04-18	Б.Билгүүн
17.	2612	Монголд үйлдвэрлэсэн шилдэг бүтээгдэхүүнд олгох гран-при цом	2016-01-12	Ү.Болдсайхан



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар

1/332

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2203006243  
дугаарыг хүчингүй болгож,  
хувийн хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Б.Мягмарсүрэн /ЧО72100318/ нь эрхийн улсын бүртгэлийн Г-2203006243 дугаарт бүртгэлтэй Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо Алтайн 8 дугаар гудамжны 242 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээсээ татгалзсан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2203006243 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2203006243 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000060695 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2203006243 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Б.Нямхандад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сүхбаатар дүүргийн Бүртгэлийн хэлтсийн дарга Б.Ариунжаргал нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/333


Улаанбаатар хот

Тендерийн баримт бичиг  
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.1, 22.1, 45.1, 47.1 дэх заалт, Хууль зүйн сайдын "Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө батлах тухай" 2017 оны А/28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагаанд шаардлагатай ХААТР маягт, лавлагаа нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн "Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт"-ийг нэгдүгээр, "Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт"-ийг хоёрдугаар, "Жагсаалт, тоо ширхэг, нийлүүлэлтийн хуваарь"-ийг гуравдугаар, "Техникийн тодорхойлолт"-ийг дөрөвдүгээр, "Гэрээний тусгай нөхцөл"-ийг тавдугаар хавсралтын ёсоор баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт өртөг, тоо хэмжээнд багтаан хуулийн дагуу зохион байгуулахыг "Үнэлгээний хороо"-ны дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Р.СОДХҮҮ



**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**



**ХААТР МАЯГТ, ЛАВЛАГАА ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер  
шалгаруулалт/  
гэрээнийнэр,  
дугаар:

**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ХААТР МАЯГТ, ЛАВЛАГАА НИЙЛҮҮЛЭХ  
ТЕНДЕР №ОӨУБЕГ/201704**

.....

Тендер шалгаруулалтын  
журам: Хязгаарлагдмал тендер шалгаруулалт

Улаанбаатар 2017 он

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны *Маягт* дүгээр тушаалын *Хавсралт*



**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	<b>А. Ерөнхий зүйл</b>
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: <b>ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</b>
ТӨӨЗ 1.1	Тендер шалгаруулалтын онцгой журмын нэр болон ялгдах дугаар: <b>ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХААТР МАЯГТ, ЛАВЛАГАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР - ОӨУБЕГ/201704</b>
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий 1 багцаас бүрдэнэ: <b>ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХААТР МАЯГТ, ЛАВЛАГАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕР - ОӨУБЕГ/201704</b>
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Улсын төсвийн хөрөнгө</i>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
ТӨӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <i>Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв байр, 1-р давхар 105 тоот Ц.Ганчимэг Утас: 320907, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 3</i>
ТӨӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.
	<b>В. Тендер бэлтгэх</b>
ТӨӨЗ 11.1	Тендерийн хэл нь <i>Монгол хэл байна.</i>
ТӨӨЗ 12.1 (в)	<i>Итгэмжлэл нь иргэний хуульд заасан шаардлагыг хангасан байна.</i>
ТӨӨЗ 12.1 (ё)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: a. <i>Үнэт цаас хэвлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;</i> b. <i>Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон хүүгийн талаарх тодорхойлолт;</i> c. <i>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;</i> d. <i>Татварын байгууллагын цахим тодорхойлолт;</i> e. <i>Шүүхийн тодорхойлолт;</i> f. <i>ШШГЕГ-ын тодорхойлолт;</i> g. <i>Гэрээг гүйцэтгэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршилага;</i> h. <i>Гэрээг хэрэгжүүлэх техникийн болон нууцлалын хүчин чадлын тодорхойлолт, техникийн гэрчилгээ;</i> i. <i>Гэрээг гүйцэтгэгч өөрийн хэвлэлийн үйлдвэрийн байртайг нотлох баримт бичиг /үйлдвэрийн байр нь өөрийнх бол эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээний хуулбар, хэрэв тухайн үйлдвэрийн байр нь түрээсийнх бол түрээсийн гэрээ/;</i> j. <i>Үйлдвэрийн байр нь дохиолол, хамгаалалттайг нотлох баримт /дохиолол хамгаалалтын системийн гэрээ, харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлж буй байгууллагын товч тодорхойлолт, тусгай зөвшөөрлийн хуулбар/</i>

	<p>к. Сүүлийн 2 жилд үйлдвэрлэсэн нууцлал бүхий бүтээгдэхүүний жагсаалт;          л. Энэхүү бараатай ижил төстэй барааг чанартай үйлдвэрлэж гүйцэтгэсэн тухай 3-аас доошгүй байгууллагын тодорхойлолт;          м. Техникийн тодорхойлолтонд заасан бараа, бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээс 1 ширхэгийг загвар, дээж /доторхи бичвэргүй байж болног ирүүлнэ.</p>
ТӨӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй. 5296722 - 1116 127152
ТӨӨЗ 15,9 (а) (3)	Үнэт цаас, маягт хүргэгдэх газар: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 3, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын төв байр,
ТӨӨЗ 15,9 (б) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэхийг хориглоно.
ТӨӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют: Төгрөг
ТӨӨЗ 17	Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт: Шаардлагатай
ТӨӨЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил /2015, 2016 оны жилийн эцсийн/
ТӨӨЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил /2015, 2016 он/
ТӨӨЗ 18.1 (д)	Үнэт цаас, маягтыг нийлүүлсний дараах үйлчилгээ: шаардлагатай -Чанарын шаардлага хангаагүй тоо хэмжээгээр дахин нийлүүлнэ
ТӨӨЗ 18.2 (а)	Тендерт оролцогчийн борлуулалтын хэмжээ: 2016 оны борлуулалтын орлогын хэмжээ нь санал болгож байгаа үнийн дүнгийн 60%-тай тэнцүү буюу түүнээс дээш байна.
ТӨӨЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн гол тоног төхөөрөмжийн жагсаалт: - стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж - хатуу дугаарлагч бүхий төхөөрөмж - нууцлалын талаарх онцлог, шалгалт туршилт хийх төхөөрөмж - багцлах, боох тоног төхөөрөмж
ТӨӨЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож байгаа үнийн дүнгийн 50 хувьтай тэнцүү буюу түүнээс дээш байх шаардлагатай.
ТӨӨЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүүг үнэлгээнд тооцно.
ТӨӨЗ 20.1	Тендер хүчинтэй байх хугацаа нь тендер нээснээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨӨЗ 21.1	Тендерийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь: -2 410 500 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
ТӨӨЗ 21.4, 21.5	Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа: - Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байх буюу 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдрийг дуустал
ТӨӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: 1 хувь Г. Тендер ирүүлэх
ТӨӨЗ 23.3 (б)	Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь "ЭХ ХУВЬ", "ХУУЛБАР ХУВЬ" гэсэн бичиглэл бүхий дугтуй буюу хавтсанд хийж битүүмжлэх ба тэдгээрийг нийлүүлэн нэг болгон битүүмжилж ирүүлнэ. Дугтуйны гадна талд ТӨӨЗ-ны 23.3-т заасан мэдээллүүдийг бичсэн байна.
ТӨӨЗ 23.3 (в)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ:  ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХААТР МАЯГТ, ЛАВЛАГАА НИЙЛҮҮЛЭХ - ОӨУБЕГ/201704

2017.07.03  
 Төрийн захирлын  
 Тамга  
 5296722 -  
 1116 127152

ТӨӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Цаг: 10 цаг 00 минут
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТӨӨЗ 28.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг: Байшин, гудамжны нэр: Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв байр Давхар болон өрөөний дугаар: 1-р давхар, хурлын заал, 104 тоот Аймаг, хот: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг Шуудангийн дугаар: Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг: Огноо: 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Цаг: 10 цаг 50 минут
ТӨӨЗ 35.2 (г)	Дараах баталгааг ирүүлнэ. Үүнд: -Тендерт ирүүлсэн загвар нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагаар хэвлэгдсэн болон нууцлалын талаарх мэдээллийн баталгааг гаргаж ирүүлнэ.
	Е. Гэрээ байгуулах эрх олгох
1. Иргэн С.Содномдорж нарын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож буй Тамгын газрын Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга Т.Ганжаргал, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Оюунбилэг нарт хуульд заасны дагуу нэхэмжлэгчтэй эвлэрэн хэлэлцэх эрх олгосугай.

2. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.Ганжаргал, Ц.Оюунбилэг нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/342

Улаанбаатар хот


Итгэмжлэгдсэн төлөөлөгчид эрх олгох  
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Б.Мягмарсүрэнгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож буй Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Оюунбилэгт хуульд заасны дагуу нэхэмжлэгчтэй эвлэрэн хэлэлцэх эрх олгосугай.

2. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Оюунбилэгт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 06 өдөр

Дугаар

А/343

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2203005502  
дугаарыг хүчингүй болгож, Y-2203000582  
дугаартай бүртгэлд нэгтгэх тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн З.Мандах /УЖ68110823/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2203005502 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Бага тойруу гудамж, 1 дүгээр байрны 32 тоот хаягт байрлах орон сууцыг эрхийн улсын бүртгэлийн Y-2203000582 дугаарт бүртгэлтэй уг байрны 29 тоот орон сууцтай нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2203005502 дугаарыг хүчингүй болгож, Y-2203000582 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2203005502 дугаартай бүртгэлийг Y-2203000582 дугаартай бүртгэлд нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн 000584044, 000584043 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2203005502 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Y-2203000582 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ц.Уянгад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Ариунболд нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/344

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Э.Нямсүрэнгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч Балын Лхагвасүрэнг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Лхагвасүрэнд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын дарга Д.Болормаад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/345

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн Л.Норжинсүрэн, Б.Золзаяа, Б.Золбаяр нарын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Буяннэмэхийн Булгантамирыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Булгантамирт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/346

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн  
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн Говьсүмбэр аймгийн Хяналтын улсын байцаагчийн 132 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг давхардуулж олгосон тул Говьсүмбэр аймгийн Хяналтын улсын байцаагчийн 132 дугаартай дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай:

1.1. иргэн М.Эрдэнэбилэг /КИ56030710/, Э.Энхтөр /КИ88121917/, Э.Номин-Эрдэнэ /КИ85072902/, Д.Наранцэцэг /КИ64111406/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1902000783 дугаарт бүртгэлтэй, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр баг, 129 дүгээр байрны 03 тоот хаягт байрлах, орон сууцны зориулалттай 000020014 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч Э.Ууганбатад зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 10 өдөр

Дугаар

1/347

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголиан коппер корпорейшн" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч Балын Лхагвасүрэн, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Үржинсүрэн нарыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Лхагвасүрэн, Д.Үржинсүрэн нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Д.Болормаад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/348

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ихэр нева" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч Балын Лхагвасүрэнг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Лхагвасүрэнд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Д.Болормаад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар

А/349

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1018003987,  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. иргэн Г.Чогний /ЙН085031305/-н өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1018003987 дугаарт бүртгэлтэй, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 4 дүгээр баг, 19-308 тоот хаягт байрлах, хувийн сууцыг нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийг үндэслэн эрхийн улсын бүртгэлийн Y-1018003987 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1018003987 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000109837 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1018003987 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Эрдэмзаяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга З.Буянбадрах нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/350

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-1112000013,  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. иргэн М.Дагвасүрэн /КЙ67070670/, Н.Өлзийсайхан /КЙ70022768/, Д.Азжаргал /КЙ92121600/, Д.Азаяа /КЙ94051801/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-1112000013 дугаарт бүртгэлтэй, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Цаг-Уурын 1-4 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээс татгалзсан байх тул өмчлөгчдийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-1112000013 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-1112000013 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000061659 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-1112000013 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч Б.Азжаргалд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Өмнөговь аймгийн аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/351

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1423000097  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Л.Оюунбилэг /НЭ78041301/-ийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1423000097 дугаарт бүртгэлтэй, Төв аймгийн Эрдэнэ сумын 3 дугаар баг Хүүшийн адагт 03 тоот хаягт байрлах хувийн сууц нь шатаж устсан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-1423000097 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1423000097 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000157584 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1423000097 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах улсын бүртгэгч Ш.Батсүхэд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Н.Энхбат нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар

#/352

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-1617001861  
дугаарыг хүчингүй болгож, Г-1617004051  
дугаартай бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Иргэн Ж.Өнөр /ПЮ38010313/ нь эрхийн улсын бүртгэлийн Г-1617001861 дугаарт бүртгэлтэй, Ховд аймгийн Жаргалант сум, 4 дүгээр баг, Бугат 19 дүгээр гудамжны 12б тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг, эрхийн улсын бүртгэлийн Г-1617004051 дугаарт бүртгэлтэй Ховд аймгийн Жаргалант сум, 4 дүгээр баг Бугат 19 дүгээр гудамжны 12 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газартай нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-1617001861 дугаарыг хүчингүй болгож, эрхийн улсын бүртгэлийн Г-1617004051 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-1617001861 дугаарыг хүчингүй болгож Г-1617004051 дугаартай бүртгэлд нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000316721, 000208504 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-1617001861 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Г-1617004051 дугаарт нэгтгэж бүртгэсэн эд хөрөнгөд шинээр гэрчилгээ олгохыг Ховд аймгийн Улсын бүртгэл хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Н.Жавзандуламд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 1/353

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банкны нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Лхагвын Оюунчимэгийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Оюунчимэгт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ж.Адилбишд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



P.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/354

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Б.Алтанцэцэгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр нэмж Хяналтын газрын хяналтын улсын байцаагч Шүхэртийн Уртнасанг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Уртнасанд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэгт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Р.СОДХҮҮ 



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/355

Улаанбаатар хот

Дүгнэлт хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 47 дугаар тогтоолоор баталсан Улсын бүртгэлийн хяналтын дүрмийн 4.3 дахь хэсэг, хяналтын улсын ахлах байцаагчийн 2017 оны 623 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Л.Бямбаноров, Л.Батсүрэн нараас тус тус ирүүлсэн өргөдлийн дагуу хянахад "Суварга констракшн" ХХК-ийн өмчлөлд эрхийн улсын бүртгэлийн Y-2101013152, Y-2101013155 дугаарт бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг эрхийн улсын бүртгэлийн Y-2101018895, Y-2101018897, Y-2101018899 дугааруудад салгаж бүртгэсэн бүртгэл нь улсын бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчөөгүй болох нь Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны А/222 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, Хяналтын газрын хяналт, шалгалтаар тогтоогдож байх тул "Эрхийн улсын бүртгэлийн Y-2101018895, Y-2101018899 дугаартай бүртгэлүүдийг хүчингүй болгох тухай" хяналтын улсын ахлах байцаагчийн 2016 оны 1553 дугаартай дүгнэлтийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Хяналтын улсын ахлах байцаагчийн 2016 оны 1553 дугаартай дүгнэлтийг хүчингүйд тооцсонтой холбогдуулан улсын бүртгэлийн цахим сангийн дүгнэлтийн бүртгэлийн санд хүчингүй төлөвт оруулж хүчингүй болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мэдээллийн технологийн газрын дарга С.Чинбат, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэг нарт даалгасугай.

ДАРГА, ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

П.СОДХҮҮ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ**

14171 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Цагдаагийн гудамж, Утас: 351245, Факс: (976-11) 351245  
<http://www.burtgel.gov.mn>

2017.01.28 № 629

2016 оны 1553 дугаартай  
дүгнэлтийг хүчингүйд тооцох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 10.5, Улсын бүртгэлийн хяналтын дүрмийн 2.1.3, 4.3, Оюуны өмч, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журмын 22.1 дэх хэсэгт заасныг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Иргэн Л.Бямбаноровоос ОӨУБЕГ-ын даргын нэр дээр ирүүлсэн "ОӨУБЕГ-ын Хяналтын газрын дарга Ч.Эрдэнэчимэг нь хариу өгөхдөө эрхийн улсын бүртгэлийн Y-2101018895, Y-2101018897, Y-210108899 дугаартай бүртгэлд өөрчлөлт оруулах боломжгүй гэж мэдэгдсэнийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т, 11-р зүйлийн 11.5.3-т, 14-р зүйлийн 14.1.1-т, 5.2-р заалтуудыг зөрчсөн Орхон аймгийн Y-2101018895, Y-2101018897, Y-210108899 дугаартай бүртгэлийг хүчингүй болгож "Суварга констракшн" ХХК-ны өмчлөлд буцаан тушаал гарган шийдвэрлэж өгөхийг танаас хичээнгүйлэн хүсэж байна" гэх өргөдөл, мөн иргэн Л.Батсүрэнгээс тус газарт ирүүлсэн "Орхон аймгийн Баян-Өндөр сум дахь 7-р хорооллын 1, 3 орон сууцанд Л.Батсүрэнгийн нэр дээрх өмчлөх эрхийн гэрчилгээ, БНХАУ-ын иргэн Вү Жиншаны нэр дээрх өмчлөх эрхийн гэрчилгээг салган бүртгэсэн бүртгэл нь МУ-д хэрэгжиж буй хууль дүрмийг зөрчөөгүй тул хэвээр нь үлдээж шийдвэрлэж өгнө үү" гэх гомдлын дагуу холбогдох бүртгэлийн нотлох баримтыг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1."Суварга констракшн" ХХК нь 3 гишүүнтэй бөгөөд хувьцаа эзэмшигчээр Л.Батсүрэн 45 хувь, Л.Бямбаноров 35 хувь, БНХАУ-ын иргэн Вү Жин Шан 20 хувийн хувьцаа эзэмшдэг байна.

2."Суварга констракшн" ХХК-ийн 2015 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр Орхон аймгийн Баян-Өндөр суманд байрлалтай, тус компанийн өмчлөлийн 2 үл хөдлөх хөрөнгийг хувьцаа эзэмшигчид өөрсдийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр хуваан авахаар шийдвэрлэсэн ба уг хуралд 35 хувийн хувьцаа эзэмшигч Л.Бямбаноров оролцоогүй байна.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч М.Отгонбаяр нь эрхийн улсын бүртгэлийн Y-210103152 дугаарт "Суварга констракшн" ХХК-ийн өмчлөлд бүртгэлтэй 3305,7 м.кв талбай бүхий орон сууцны зориулалттай барилгаас 2015 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 1061,98 мкв талбайг иргэн Л.Батсүрэнд, 2015 оны 5 дугаар сарын 01-ний өдөр 1067,2 м.кв талбайг БНХАУ-ын иргэн Ву Жин Шангийн өмчлөлд, 1176,52 мкв талбайтай хэсгийг "Суварга констракшн" ХХК-ийн өмчлөлд, эрхийн улсын бүртгэлийн Y-2101013155 дугаарт "Суварга констракшн" ХХК-ийн өмчлөлд бүртгэлтэй 2203,8 мкв талбай бүхий орон сууцны зориулалттай барилгаас 2015 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 1290,4 м.кв талбайг Л.Батсүрэнд, 913,4 мкв талбайтай хэсгийг 2015 оны 10 сарын 22-нд "Суварга констракшн" ХХК-ийн өмчлөлд тус тус салгаж бүртгэсэн байна

4. Орхон аймгийн Цагдаагийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 40/042388 дугаартай албан бичгээр эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа үндэслэлээр Л.Батсүрэнгийн өмчлөл бүхий эрхийн улсын бүртгэлийн Y-2101018895, БНХАУ-ын иргэн Ву Жин Шангийн өмчлөл бүхий эрхийн улсын бүртгэлийн Y-2101018899 дугаартай бүртгэлийн шилжилт хөдөлгөөнд хориг тавьж, Орхон аймгийн прокурорын газрын 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 5/38 дугаартай албан бичгээр хоригийг цуцалсан байна.

5. Иргэн Л.Батсүрэнгээс 2015 оны 10 дугаар сарын 01-ны өдөр, Л.Бямбаноровын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр тус тус гаргасан гомдлын дагуу "Суварга констракшн" ХХК-ийн дээр дурдсан бүртгэлтэй холбоотой асуудлаар Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Бүртгэлийн хяналтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Б.Ганбаатар, хяналтын улсын байцаагч Ш.Мөнх-Од нар 2016 оны 1 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст ажиллаж, холбогдох бүртгэлийн нотлох баримтыг хянаж, шалгалтын дүнгийн талаар Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын дарга С.Мэндсайханд 2016 оны 2 дугаар сарын 01-ний өдөр илтгэх хуудсаар танилцуулж, бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн улсын бүртгэгч М.Отгонбаярт Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах, "Суварга констракшн" ХХК-ийн холбогдох бүртгэлийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын тушаалаар хүчингүй болгох саналыг оруулсан байна.

6. "Суварга констракшн" ХХК-ийн гаргасан гомдлын дагуу Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/222 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, ажлын хэсгээс гаргасан дүгнэлтээр "эрхийн улсын бүртгэлийн Y-2101013152, Y-2101013155 дугаартай бүртгэлүүдээс салгаж бүртгэсэн бүртгэлүүд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчөөгүй байна." гэж дүгнэн, энэ тухай иргэн Л.Бямбаноровт албан бичгээр харуу өгсөн байна.

7. Иргэн Л. Бямбаноровын гомдлоор улсын бүртгэгч М. Отгонбаярт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 115<sup>1</sup> дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тогтоолоор, 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 5/291 дугаартай эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай прокурорын тогтоолоор тус тус хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

8. Иргэн Л. Батсүрэн, Ву Жин Шан нарт залилуулсан гэх гомдлын дагуу УМБГ-ын Хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтсээс шалгаж, Нийслэлийн прокурорын газрын прокурорын 2017 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаартай тогтоолоор эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

9. Орхон аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 40/04/2516 дугаартай албан бичигт "Орхон аймгийн Улсын бүртгэлийн газрын эд хөрөнгийн улсын бүртгэгч М. Отгонбаярын "Суварга констракшн" ХХК-ийн эд хөрөнгийг хувьцаа эзэмшигч нарт салгаж бүртгэсэн бүртгэлийн ажиллагаанд урьд өмнө хяналтын байцаагч шалгаж, холбогдох саналыг гаргасан бөгөөд гомдол гаргагч нарт өгсөн хариу, шалгагч нарын санал нь зөрүүтэй байх тул шалгалтыг дахин явуулж, шийдвэрийг ирүүлнэ үү" гэсэн байна.

Иймд дээрх бүртгэлийн маргаантай холбоотой асуудлыг ОӨУБЕГ-ын даргын 2016 оны А/196 дугаар тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцэн хяналт шалгалт явуулаад дүгнэлт гаргуулах санал гаргасны дагуу хяналтын улсын ахлах байцаагч Ж. Чиймаагийн 2016 оны 1553 дугаартай дүгнэлт гарч "эрхийн улсын бүртгэлийн Y-2101018895, Y-2101018899 дугаартай бүртгэлүүдийг ОӨУБЕГ-ын даргын тушаалаар хүчингүй болгох нь зүйтэй" гэж дүгнэсэн байна.

10. Иргэн Л. Бямбаноровын 2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр тус газарт гаргасан "...иргэн Л. Батсүрэн, Ву Жиншин нарын нэр дээр "Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн Y-2101018895, Y-2101018897, Y-2101018899 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ"-нүүдийг хуваан, салгаж бүртгэсэн бүртгэлийг хүчингүй болгож, хууль ёсны эзэмшигч "Суварга констракшн" ХХК-ийн нэр дээр нэн даруй яаралтай шийдвэрлэж өгөхийг хүсье гэсэн хүсэлтэд Хяналтын газрын даргын 2017 оны 4/1683 дугаартай албан бичгээр Захиргааны ерөнхий хуулийн 27.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.3-т заасныг үндэслэл болгон бүртгэлд өөрчлөлт оруулахгүйг мэдэгдсэн.

ДҮГНЭХ нь:

"Суварга констракшн" ХХК-ийн дүрмийн 6.1-д Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хуулийн 59.1 дэх хэсэгт зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурал байна, 6.2-т Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит ба ээлжит

бус хурал, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох ... асуудлыг Компанийн тухай хуулийн 59-74 дүгээр зүйлд зааснаар зохицуулна гэж заасан байна.

1.Компанийн тухай хуулийн 69.1.Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

69.2.Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн хувийг энэ хуулийн 69.1-д зааснаас дээгүүр тогтоож болно. /дээгүүр тогтоогоогүй байна./

69.4.Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор энэ хуулийн 69.3-т заасны дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно гэж заасны дагуу "Суварга констракшн" ХХК-ийн 2015 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд компанийн 65%-ийн хувьцаа эзэмшигчид оролцож, асуудлыг 100%-ийн саналаар шийдвэрлэсэн тул уг шийдвэр хүчин төгөлдөр байна.

2.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.4.Үл хөдлөх хөрөнгийг дундаа хэсгээр өмчилж байгаа өмчлөгч тус бүр өөрт ногдох хэсгээ бүртгүүлэхээр бие даан мэдүүлэг гаргана гэж заасны дагуу иргэн Л.Батсүрэн, Ву Жиншин нар нь "Суварга констракшн" ХХК-ийн өмчлөлд бүртгэлтэй байсан орон сууцнаас өөрт ногдох хэсгээ тус тус улсын бүртгэлд салгаж бүртгүүлэхээр мэдүүлэг гаргах үед Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан мэдүүлэг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаагүй байна.

3.Хяналтын улсын ахлах байцаагч Ж.Чиймаагийн 2016 оны 1553 дугаартай дүгнэлтэд Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн хуулийн 19.2-т заасныг зөрчсөн гэж дүгнэсэн байх бөгөөд хуулийн уг заалт нь тухайн бүртгэлд хамааралгүй байна.

4.Иргэн Л.Батсүрэн, Ву Жиншин нар нь өөрт ногдох хэсгээ улсын бүртгэлд бүртгүүлэхэд үндэслэл болсон "Суварга констракшн" ХХК-ийн 2015 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал, мөн хурлаас гарсан шийдвэр, тогтоолыг хүчин төгөлдөр бусд тооцсон төрийн эрх бүхий хууль, хяналтын байгууллагын шийдвэр байхгүй байна.

5."Эрхийн улсын бүртгэлийн Y-2101018895, Y-2101018899 дугаартай бүртгэлүүдийг хүчингүй болгох тухай" хяналтын улсын ахлах байцаагч Ж.Чиймаагийн 2016 оны 1553 дугаартай дүгнэлт гарснаар өмчлөгч нь ямар субъект байхаас үл хамааран тухайн хөрөнгө нь улсын бүртгэлд бүртгэлгүй болох улмаар өмчлөх эрхийн маргаан гарах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Иймд Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрхэд заасан, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.1.5.улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, түүний хууль зөрчсөн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 47 дугаар тогтоолоор баталсан Улсын бүртгэлийн хяналтын дүрмийн 4.3."Улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг дээд шатны улсын байцаагч шийдвэрлэх..." гэж заасныг удирдлага болгон:

1."Эрхийн улсын бүртгэлийн Y-2101018895, Y-2101018899 дугаартай бүртгэлүүдийг хүчингүй болгох тухай" хяналтын улсын ахлах байцаагч Ж.Чиймаагийн 2016 оны 1553 дугаартай дүгнэлтийг Ерөнхий байцаагчийн шийдвэрээр хүчингүйд тооцох;

2.Компанийн хувьцаа эзэмшигч Л.Бямбаноровт ногдох хэсгийг улсын бүртгэлд бүртгээгүй байгаа нь, мөн Л.Батсүрэн, Ву Жиншин нар нь өөрт ногдох хэсгээ улсын бүртгэлд бүртгүүлсэн нь улсын бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчөөгүй байна гэж дүгнэв.

ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ



Ч.ЭРДЭНЭЧИМЭГ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/356

Улаанбаатар хот

Сургалт-танилцах айлчлалд  
хамруулах тухай


Монгол Улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дүгээр заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ухаалаг Засаг” төслийн хүрээнд 2017 оны 4 дүгээр сарын 16-наас 22-ний өдрүүдэд Тайландын Вант Улсын Бангкок хотноо зохион байгуулж буй “Сервер болон сүлжээний виртуалт” сэдэвт сургалт болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн системийн талаар туршлага судлах айлчлалд Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн сан, програм хангамжийн хэлтсийн дарга П.Нэргүй, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Ө.Өнөрлхам, Мэдээллийн технологийн газрын инженер А.Лхагвасүрэн нарыг төслийн санхүүжилтээр хамруулсугай.

2. Тус арга хэмжээнд идэвхтэй оролцож, үр дүнгийн талаар Даргын зөвлөлийн хуралд мэдээлэл хийхийг танилцах айлчлалын багийн ахлах /Д.Батболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



БАТЛАВ  
ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА Р.СОДХҮҮ

**ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСАД  
ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭДЭЭР ТУРШЛАГА СУДЛАХ СУРГАЛТ-АЙЛЧЛАЛ**

**Сургалтын нэр:** “Сервер болон сүлжээний виртуалт” сэдэвт сургалт болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн системийн талаар туршлага судлах айлчлал

**Хаана:** Тайландын Вант Улс

**Хэзээ:** 2017 оны 4 сарын 17-21

**Оролцох хүний тоо:** 4

**Төсөл хэрэгжүүлэгч:** Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар

**Төслийн дугаар:** 154413

**Үйл ажиллагааны дугаар:** Төслийн Худалдан авалтын төлөвлөгөөний 2.4.6

**Оршил**

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ухаалаг Засаг” төслийн хүрээнд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт “Эд хөрөнгийн эрхийн цахим бүртгэлийн системийг Монгол Улсад бүрэн нэвтрүүлэх” дэд бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлж байна.

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, эд хөрөнгийн эрхийн цахим бүртгэлийн (ePRS) програм хангамжийг сайжруулах, эрхийн бүртгэлийн нэгдсэн цахим системд холбогдоогүй 13 аймгийн бүртгэлийн төвүүдийг сүлжээнд холбож Монгол Улсын нийслэл, бүх аймгийг хамарсан Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нэгдсэн сүлжээ бий болгох замаар эрхийн бүртгэлийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлэх, эрхийн бүртгэлийн нэгжүүдийн чадавхийг нэмэгдүүлж цахим бүртгэлийн орчин бүрдүүлэхэд оршино.

**Сургалт-айлчлалын зорилго**

“Эд хөрөнгийн эрхийн цахим бүртгэлийн системийг Монгол Улсад бүрэн нэвтрүүлэх” дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд мэдээлэл технологийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх ажил төлөвлөгдсөн.

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.4.6-д заасан Чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд энэхүү сургалт-айлчлалыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Сургалтын айлчлалын зорилго нь Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл технологийн ажилтнуудын сервер болон сүлжээний виртуальчлалын чиглэлээр чадавхийг бэхжүүлэх, эд хөрөнгийн нэгдсэн системийн талаар туршлага судлахад оршино.

#### Сургалт-айлчлалын бүрэлдэхүүн

- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд,
- Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн сан, програм хангамжийн хэлтсийн дарга П.Нэргүй,
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Ө.Өнөрхлам,
- Мэдээллийн технологийн газрын инженер А.Лхагвасүрэн

#### Сургалт-айлчлалын агуулга

Сургалт-айлчлалыг Тайланд улсын AIT RRC сургуулийн дэргэдэх сургалтын төвөөс удирдан дараах агуулгын хүрээнд сургалтыг зохион байгуулна:

- Сервер болон сүлжээний виртуальчлалын ойлголт
- Сервер болон сүлжээний виртуальчлалын ашиглалт
- Сүлжээний хамгаалалтыг сайжруулах
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн систем

#### Гарах үр дүн

- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нэгдсэн системийн талаарх ойлголт, мэдлэг сайжирна.
- Олсон мэдлэг, туршлагад үндэслэн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн системийг сайжруулах, бэхжүүлэх үр чадвар дээшилнэ.
- Сургалтын талаар хамтран ажиллах байгууллага, хүмүүст мэдээлэл хүргэнэ.
- Холбогдох гарын авлага материалыг түгээх ажил зохион байгуулна.

#### Төсөв

№	Зардлын зүйл	Нэгж үнэ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Өдөр	Нийт үнэ
1	Онгоцны билет	850,0	Хүн	4		3400,0
2	Томилолтын зардал	140,0	Хүн	4	5	2800,0
4	Хот дотор зорчих унааны зардал	10,0	Хүн	4	5	200,0
5	Эрүүл мэндийн даатгал	15,0	Хүн	4		60,0
6	Сургалтын төлбөр	500,0	Хүн	4		2000,0
	<b>НИЙТ</b>					<b>8460,0</b>

Хянасан:

Тамгын газрын дарга

Б.Бадамцэцэг

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга

Д.Батболд

Боловсруулсан:

Мэдээллийн технологийн газрын дарга

С.Чинбат



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/357

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жангар цамхаг" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Самбуугийн Даваадоржийг томилсугай.


2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Даваадоржид, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ





**ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/358

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2202008418  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Брикланд" ХХК /5255937/-ийн өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202008418 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо, Хайлаастын 2 дугаар гудамжны 01 тоот хаягт байрлах, үйлчилгээний зориулалттай барилгаа нурааж, буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2202008418 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202008418 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000104901 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202008418 дугаартай хувийн хэрэгт бүртгэл болон цахим санд холбогдох бичилт хийж хаахыг Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Х.Болорчулуунд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Ганчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

Handwritten notes and signatures in blue ink at the bottom right of the document.



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 1/359

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2203009386 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ц.Ганбат /ИЮ76033012/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2203009386 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, Барилгачдын 3 дугаар гудамжны 48 тоот хаягт байрлах, хувийн сууцаа нурааж буулгасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2203009386 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2203009386 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000053719 дугаартай гэрчилгээг хүчингүйд тооцсугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2203009386 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Г.Ичинхорлоод зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Ариунжаргал нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Г.СОДХҮҮ





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/360

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2203009104  
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,  
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

